



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**



МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ

**АЮУЛГҮЙ, ЭРҮҮЛ, ХҮНДЛЭЛТЭЙ
АЖЛЫН БАЙРНЫ ПРОТОКОЛ**



ТУУТ (TSM) СТАНДАРТЫН ҮНЭЛГЭЭНИЙ ПРОТОКОЛ

АЮУЛГҮЙ, ЭРҮҮЛ, ХҮНДЛЭЛТЭЙ АЖЛЫН БАЙРНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЭХ АРГА ХЭРЭГСЭЛ

Зорилго

Үнэлгээний протоколын зорилго нь байгууллагуудад аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны гүйцэтгэлийг ТУУТ стандартийн үзүүлэлтүүдийн дагуу үнэлэхэд зааварчилгаа өгөхөд оршино. Энэхүү протокол нь ТУУТ стандартийн аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтцийн хэрэгжилтийг дэмждэг.

Менежментийн тогтолцооны аливаа үнэлгээний адил тогтолцоо эсвэл үзүүлэлт болон менежментийн үйл явц ба хөндлөнгийн оролцооны чанарын хэр хэмжээг үнэлэхэд мэргэшсэн шүүлт шаардлагатай.

Иймд энэхүү протоколыг хэрэгжүүлэхэд аудит ба тогтолцооны үнэлгээний чиглэлээр тодорхой түвшинд мэргэшсэн байх, мөн аюулгүй, хүндлэлтэй ажлын байрны удирдлагын тогтолцоо ба хэрэгжилтийн талаар мэдлэг, туршлага байх шаардлагатай

Энэхүү үнэлгээний протокол нь ТУУТ стандартийн нэг хэсэг болох аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны идэвхтэй хэрэгжилтийн түвшинг үнэлдэг.

Энэ нь аюулгүй, эрүүл, хүндлэлтэй үйл ажиллагааны үр нөлөөтөй байдлын баталгаа болохгүй. Протокол нь ажлын байранд дагаж мөрдөх хууль тогтоомжийн нийцлийг төлөөлөхгүй.

Гүйцэтгэлийн үзүүлэлтүүд

Аюулгүй байдал, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны протокол нь 6 үзүүлэлтээс бүрдэнэ:

1. Үүрэг амлалт ба эгэх хариуцлага
2. Аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоо
3. Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйл
4. Сургалт, зан үйл ба соёл
5. Мониторинг болон тайлагнал
6. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэл

Энэхүү протокол нь бие махбодийн аюулгүй байдал, эрүүл мэндийг удирдах шилдэг туршлагаудад төвлөрч, сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэлтэй зан үйлийг бэхжүүлэх шаардлагуудыг нэвтрүүлж, хэрэгжүүлж буй аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоонд сэтгэл санааны эрүүл мэнд ба аюулгүй байдлын асуудлыг нэгтгэх зорилтот өөрчлөлтүүдийг тусгасан болно.

Компаниудын эдгээр чиглэлийн үйл ажиллагаагаа сайжруулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор протокол болон түүний бүтцэд (шинэ үзүүлэлтийг оруулаад) нэмэлт өөрчлөлт оруулсан. Эцсийн дүнд үүний зорилго нь сэтгэл санааны эрүүл мэнд ба аюулгүй байдлыг салбарын салбарын хүрээнд хэрэгжүүлж буй аюулгүй байдал ба эрүүл мэндийг удирдах тогтолцоонд бүрэн нэгтгэх явдал юм.

Энэхүү протокол нь тэгш ба хүртээмжтэй байдал болон оролцооны талаархи корпорацийн стратегийн шаардлага түүнчлэн уурхайн түвшний тэгш ба хүртээмжтэй байдал болон оролцооны соёлыг төлөвшүүлэх шаардлагыг тусгасан ТУУТ стандартын тэгш, олон янзын, оролцоотой ажлын байрны протоколтой нягт холбоотой.

ТУУТ стандартын Эрүүл, аюулгүй, хүндлэлтэй ажлын байрны протокол дахь сэтгэл санааны аюулгүй байдалтай холбоотой шинэ шаардлагууд нь тэгш, олон янзын байдал болон оролцоог хангахад чухал үндэс суурь болдог. Мөн эсрэгээр байж болно.

Компаниуд нь аюулгүй байдал, хүний нөөц болон бизнесийн бусад чиглэлийн дотоодын шинжээч ажиллуулж хоёр протоколын хамтатган хэрэгжүүлэх арга хэрэглэх боломжтой.

ҮЗҮҮЛЭЛТ 1: ҮҮРЭГ АМЛАЛТ БА ЭГЭХ ХАРИУЦЛАГА

Зорилго

Байгууллага нь аюулгүй байдал, эрүүл мэнд, хүндлэлтэй ажлын байрны талаар үүрэг амлалт авч, аюулгүй байдал, эрүүл мэнд, хүндлэлтэй ажлын байрны удирдлага, гүйцэтгэлийн талаар тодорхой эгэх хариуцлага тогтоож, ажилчид, гэрээлэгч, ханган нийлүүлэгчдэд энэ талаар тодорхой мэдээлж харилцсаныг нотлох.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Уурхай нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	- Аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үүрэг амлалт илт харагдаж байгаа. - Нэг эсвэл дээш тооны удирдлагын төлөөлөл аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны эгэх хариуцлага хүлээсэн. - Уурхай нь А түвшний бүх шаардлагыг биелүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан.
А	- ТУУТ стандартын аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтцийн зорилгод нийцсэн дээд удирдлагын аюулгүй, ажлын байрны талаарх үүрэг амлалтыг илэрхийлсэн. - Уурхайн ажилтнууд, гэрээлэгчид болон ханган нийлүүлэгч нарт компанийн аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үүрэг амлалтыг таниулдаг үйл явцтай. - Удирдлага болон ажилтнуудын үүрэг ба эгэх хариуцлагыг бүх түвшинд ойлгож мэдсэн.
АА	- Доорх зүйлсийг тодорхойлох зорилгоор дотоод аудит хийсэн: - Хүчин чармайлтууд нь ТУУТ стандартын аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтцийн зорилгод үүрэг амлалтыг хэр хэмжээнд нийцүүлж хэрэгжүүлсэн байдал. - Үүрэг хариуцлага ба эгэх хариуцлагыг удирдлага болон ажилтнууд ойлгож мэдсэн эсэх. - Үүрэг амлалтын талаар уурхайн ажилтанууд, гэрээлэгч болон ханган нийлүүлэгч нарт мэдээлж харилцсан эсэх, мөн тэдгээр талуудад мэдлэг ойлголт олгох үйл явцтай эсэх. - Уурхай ажилтнууд нь аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх өөрсдийн үүрэг амлалтыг илэрхийлж харуулсан

AAA	1. Доорх зүйлсийг тодорхойлох зорилгоор хөндлөнгийн аудит хийсэн:
	a. Хүчин чармайлтууд нь ТУУТ стандартын аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтцийн зорилгод үүрэг амлалтыг хэр хэмжээнд нийцүүлж хэрэгжүүлсэн байдал.
	b. Үүрэг хариуцлага ба эгэх хариуцлагыг удирдлага болон ажилтнууд ойлгож мэдсэн эсэх.
	c. Үүрэг амлалтын талаар уурхайн ажилтанууд, гэрээлэгч болон ханган нийлүүлэгч нарт мэдээлж харилцсан эсэх, мөн тэдгээр талуудад мэдлэг ойлголт олгох үйл явцтай эсэх.
	d. Уурхайн ажилтнууд нь аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үүрэг амлалтын талаарх мэдлэг ойлголт олгох үйл явцын үр нөлөө.

Түгээмэл асуултууд: Үүрэг амлалт/хүчин чармайлт болон эргэн тайлагнал

#	Түгээмэл асуултууд
1	“Ажлын байр” гэж юуг хэлэх вэ?
2	“Хүндлэлтэй ажлын байр” юуг хэлэх вэ?
3	“Дээд удирдлага” гэж юуг хэлэх вэ?
4	“Эгэх хариуцлага” гэж юуг хэлэх вэ?
5	“Үүрэг хариуцлага” гэж юуг хэлэх вэ?
24	Уурхайн түвшний үүрэг амлалтыг компанийн баримт бичгийг ашиглаж нотлон харуулж болох уу?
25	Аюулгүй байдал ба эрүүл мэндийн үүрэг амлалтууд нь ТУУТ стандартын аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтэцтэй нийцэж байгааг байгууллага хэрхэн тодорхойлох вэ?
26	Ажилтнууд нь аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны үүрэг амлалтаа хэрхэн илэрхийлэн харуулж болох вэ?
42	“Аудит” гэж юуг хэлэх вэ?
43	Компани эсвэл уурхай нь АА түвшний дотоод аудит хийхгүйгээр гадаад аудитыг амжилттай хийлгэснээр ААА түвшинг хангаж болох уу?
44	Дотоод болон гадаад аудит ямар хугацаанд хүчинтэй байх вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 2: АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО

Зорилго

Аюулгүй байдал ба эрүүл мэндийн хяналтыг үр нөлөөтөйгөөр төлөвлөх ба осол гарахаас сэргийлэх үйл явцуудтай болсоныг нотлох. Энэхүү үзүүлэлт нь аюулгүй байдал, эрүүл мэнд нь хамтын үүрэг хариуцлага гэдгийг хүлээн зөвшөөрч, аюулыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, үр нөлөөтөй хяналт бий болгох нь үр нөлөөтэй менежментийн тогтолцооны салшгүй хэсэг гэдгийг харуулна. Тус үзүүлэлт нь биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндэд төвлөрдөг ч зарим шаардлагууд нь сэтгэл санааны эрүүл мэндэд ба аюулгүй байдалд мөн хамаарна.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Уурхай нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	1. Аюултай тохиолдол мэдээлэх ба судлах тодорхой үйл явцуудыг багтаасан биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны зарим элементүүдийг тодорхойлсон. 2. Эрсдэлийн хянах арга хэрэгсэлийг тодорхойлж, хэрэглэхэд бэлэн болгосон. 3. Уурхай нь хамгийн түгээмэл ажлуудыг тодорхойлсон. 4. Уурхай нь хамгийн түгээмэл ажлуудад зориулсан стандарт үйл ажиллагааны заавар болон аюулгүй ажлын дадал бий болсон. 5. Уурхай нь А түвшний бүх шаардлагуудыг биелүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан.

А	- Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн баримтжуулсан менежментийн тогтолцоо бий болж, хэрэгжиж, хэвийн ажиллаж байгаа. Үүнд доорх зүйлс багтана: - Зорилтууд, хүрэх үр дүн, эдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө. - Аюул тодорхойлох ба эрсдэл үнэлэх (АТЭҮ) ба хянах үйл явцууд. - Үр дагавар ихтэй аюул ба түүний эгзэгийн хяналт тогтоох. - Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөр. - Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн үүрэг хариуцлагыг тодорхойлох. - Ажлын байрны үзлэг - Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн бүртгэл хөтлөх. - Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, ажиллуулах ба сайжруулах болон хяналтын үр нөлөөг баталгаажуулахад зориулан нөөц хуваарилах.
АА	- Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны төлөвлөлт болон хэрэгжилт нь А түвшний шаардлагыг хангаж буй эсэхэд дотоод аудит хийсэн. - Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн эрсдэл ба хяналтад мэргэшсэн эрүүл ахуйч дүн шинжилгээ хийсэн. - Уурхай нь эгзэгийн хяналт бий болж, хэвийн ажиллаж байгааг болон эгзэгийн, зайлсхийх болон энгийн хяналт хоорондын ялгааг тус тус тодорхойлж баталгаажуулсан. - Уурхай нь нийгэм-сэтгэл санааны аюул, гэмт зан үйлийг тогтоосон, болзошгүй эрсдэлийг үнэлж, удирдаж, мониторинг хийсэн.
ААА	- Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны төлөвлөлт болон хэрэгжилт нь А түвшний шаардлагыг хангаж буй эсэхэд дотоод аудит хийсэн. - Мэргэшсэн эрүүл ахуйчийн хяналт доор хэрэгждэг үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөртэй. - Уурхайн онцлог, ялангуяа аюултай ажлуудыг тодорхойлсон, мөн хяналт тодорхойлох тогтсон аргачлалаар (жишээ нь, эрвээхэй зангианы шинжилгээ) эдгээр ажлуудын эгзэгийн хяналтыг тодорхойлсон.

Түгээмэл асуултууд: аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоо

#	Түгээмэл асуултууд
6	“Аюулыг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх (АТЭҮ) гэж юуг хэлэх вэ?
7	“Хяналт” гэж юуг хэлэх вэ?
8	“Мэргэшсэн эрүүл ахуйч” гэж хэнийг хэлэх вэ?
9	“Төлөвлөлт” гэж юуг хэлэх вэ?
10	“Тогтолцоо” гэж юуг хэлэх вэ?
11	“Үр нөлөө” гэж юуг хэлэх вэ?
12	“Эгзэгийн хяналт”, “зайлсхийх хяналт” болон “энгийн хяналт” гэж юуг хэлэх вэ?
13	“Эрвээхэй зангианы шинжилгээ” гэж юуг хэлэх вэ? (bowtie analysis)
24	Уурхайн түвшиний үүрэг амлалтыг илэрхийлэн харуулахад компанийн баримт бичгийг ашиглаж болох уу?
27	Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөрт юу багтаж болох вэ?
28	Эгзэгийн хяналтын зорилтууд ба гүйцэтгэлийн шаардлагыг уурхай хэрхэн тогтоож болох вэ?
42	“Аудит” гэж юуг хэлэх вэ?
43	Компани эсвэл уурхай нь АА түвшний дотоод аудит хийхгүйгээр гадаад аудитыг амжилттай хийлгэснээр ААА түвшинг хангаж болох уу?
44	Дотоод болон гадаад аудит ямар хугацаанд хүчинтэй байх вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 3: СЭТГЭЛ САНААНЫ АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ХҮНДЛЭЛТЭЙ ЗАН ҮЙЛ

Зорилго

Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйлийг ажлын байранд төлөвшүүлэх үйл явц ба хөтөлбөрийг хэрэгжүүлж буйг нотлох.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Уурхай нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	- Уурхай нь А түвшний бүх шаардлагыг биелүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан. - Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй холбоотой аюултай тохиолдлыг мэдээлдэг ажилчдад зориулсан механизм бий болгосон.
А	- Сэтгэл санааны аюулгүй байдал ба эрүүл мэнд, хүндлэлтэй зан үйлийг төлөвшүүлэхийн тулд одоо хэрэгжиж буй бодлого ба үйл явцад дүн шинжилгээ хийсэн. - Уурхай нь эрүүл мэнд ба ая тух, түүний дотор сэтгэцийн эрүүл мэнд ба эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх ба дэмжих хөтөлбөртөй. - Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйлийг төлөвшүүлэх бодлого ба үйл явцыг ажилтнуудад мэдээлж харилцдаг. - Ажлын байран дээрх сэтгэл санаанд аюултай, гэмтэй эсвэл үл хүндэтгэсэн тааламжгүй тохиолдлыг мэдээлэх ба хариу арга хэмжээ авахад зориулсан гэмтэл- мэдээллийн үйл явцтай болсон. Үүнд дараах зүйлс багтана: - Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй холбоотой байнгын сайжруулалт хийх ба суралцах ажлын байрны соёлыг төлөвшүүлэх зорилгоор хамтран ажиллагсдын дунд тааламжгүй тохиолдлыг албан бусаар шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх сургалт ба нөөц - Тааламжгүй тохиолдлыг албан бусаар шийдэх үйл явцаас гадуур судалж шинжлэх, эсвэл шийдвэрлэхэд дэмжлэг шаардагдах асуудал, гомдол ба саналыг хүлээн авч шийдвэрлэхэд зориулсан мэдээлэл тайлагналын шуурхай, нууцлалтай, шударга механизм.

АА	1. Уурхай нь А түвшний гэмтэлийн талаар мэдээлэл хүлээн авах ба шийдвэрлэхэд зориулсан гэмтэл мэдээлийн үйл явцад дүн шинжилгээ хийхэд дотоод болон гадаад сонирхолын бүлгүүдтэй хамтран ажилладаг, шаардлагатай бол өөр хувилбар санал болгодог. 2. Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийг төлөвшүүлэх өөрийн бодлого ба үйл явцын талаар илүү өргөн хүрээний ханган нийлүүлэлтийн сүлжээнд мэдээлж харилцдаг. 3. Уурхай нь сэтгэл санааны аюулгүй ба хүндлэлийн гүйцэтгэлийн зорилтуудыг тогтоосон эсвэл компанийн түвшинд тогтоосон зорилтуудыг биелүүлдэг. Үүнд доорх зүйлс багтсан байна: а. Гүйцэтгэлийн зорилтуудыг хангах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан. б. Гүйцэтгэлийн зорилтуудыг хангахад гарч буй ахиц, энэ талаар дотооддоо тайлагнадагийг нотлон харуулна. 4. Ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, шаардлагатай үед туслах хөтөлбөрийг боловсруулсан.
ААА	А болон АА түвшний шалгуураар гурван жил тутамд дотоод аудит хийдэг. Дотоод аудит нь холбогдох хөдөлмөрийн эсвэл ажилчдын бүлгүүд болон уул уурхайн төлөөлөл багатай бүлгүүдийн хэтийн төлөв ба туршлагыг хамруулна Дотоод аудитын үр дүнг ажилчдад танилцуулж, олон нийтэд тайлагнана. Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийг олон нийтийн дунд төлөвшүүлэхийн тулд холбогдох сонирхолын бүлгүүдтэй хамтран ажилладаг. Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийн зарчмуудыг өөрийн худалдан авалтын үйл явц болон гэрээлэгчтэй харьцах харилцаанд нэгтгэсэн.

Түгээмэл асуултууд: сэтгэл санааны аюулгүй байдал, хүндэтгэлт зан төлөв

#	Түгээмэл асуултууд
15	“Сэтгэл санааны аюулгүй байдал” болон “сэтгэцийн эрүүл мэнд ба аюулгүй байдал” хоорондын ялгаа юу вэ?
16	“Сэтгэл санааны аюул” гэж юуг хэлэх вэ?
17	“Гэмтэл-мэдээлэл” гэж юуг хэлэх вэ?
18	“Гэмт зан үйл” гэж юуг хэлэх вэ?
29	Уул уурхайн салбарт төлөөлөл багатай ямар бүлгүүд байдаг вэ?
30	Компаниуд нь ажилтнуудын дунд тааламжгүй тохиолдолыг албан бусаар шийдэхэд хэрхэн дэмжлэг үзүүлж болох вэ?
31	Ажлын байран дээрх аюултай, гэмтэй, хүндлэлгүй зан үйлийн хариу өгөх механизм бүрдүүлэхэд уурхай нь юуг анхаарч үзвэл зохих вэ?
32	Дарамт, гадуурхалт, хүчирхийлэл зэрэг асуудлыг шийдэхэд ашиглаж болох гаднах механизмуудын ямар жишээ байж болох вэ?
33	Сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэл, хүртээмжийг чухалчлах ажлын байрны дизайн боловсруулахад ямар зүйлсийг анхаарч үзэх вэ?
34	Бэлгийн дарамттай тэмцэхэд компаниуд ашиглаж болох ямар эх сурвалжууд байдаг вэ?
35	Ажилчдын сэтгэцийн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт ямар зүйлс багтаж болох вэ?
36	Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийг олон нийтийн дунд төлөвшүүлэхийн тулд холбогдох сонирхолын бүлгүүдтэй уурхай хэрхэн хамтран ажиллаж болох вэ?
42	“Аудит” гэж юуг хэлэх вэ?
43	Компани эсвэл уурхай нь АА түвшний дотоод аудит хийхгүйгээр гадаад аудитыг амжилттай хийлгэснээр ААА түвшинг хангаж болох уу?
44	Дотоод болон гадаад аудит ямар хугацаанд хүчинтэй байх вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 4: СУРГАЛТ, ЗАН ҮЙЛ БА СОЁЛ

Зорилго

Ажилчид болон гэрээлэгчдийг аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үр нөлөөтэй сургах үйл явц бий болсоныг нотлох. Энэхүү үзүүлэлтийн зорилго нь ажилчид болон гэрээлэгчид аюулыг илрүүлэх, сэргийлэх чадамжтай байх, мөн аюулгүй байдал, эрүүл мэнд ба хүндлэлийг эрсдэлийн хяналтын салшгүй хэсэг бөгөөд хамтын хариуцлага гэдгийг ойлгуулахад оршино.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Компани нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	1. Уурхай дээр аюулгүй байдал ба эрүүл мэндийн аюул болон эрсдэл, үүнд үр дагавар ихтэй ажлын талаар анхан шатны сургалт явуулж, бүртгэл хөтөлдөг. 2. Уурхай дээр нийгэм-сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэлтэй зан үйл, сэтгэл санаанд учрах аюулыг илрүүлэх, нийгэм-сэтгэл санаанд нөлөөлөх эрсдлийг үнэлэх анхан шатны сургалт явуулдаг ба бүртгэл хөтөлдөг. 3. Уурхай нь А түвшний бүх шаардлагыг биелүүлэх үйл арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан.

А	1. Аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны тухай сургалт ба мэдлэг олгох хөтөлбөрийг төлөвлөж, баримтжуулж, хэрэгжүүлдэг, үүнд доорх зүйлс багтана: a. Ажилтнуудын сургалтын хэрэгцээний дүн шинжилгээ, үүнд шаардагдах ур чадвар ба чадамжийг оруулсан. b. Ажилтнууд болон уурхай дээрх гүйцэтгэгч нарт зориулсан сургалт. c. Зочдод зориулсан танилцуулах сургалт. d. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг, үүнд дүн шинжилгээний механизм багтсан. e. Сургалтын бүртгэл хөтөлдөг. f. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц хуваарилсан. g. Сургалтын хөтөлбөрийг дууссаны дараа ажилчдын чадамжийг үнэлдэг. f. Сургагч нарын чадамж ба/эсвэл сургалтын хөтөлбөрийн чанарыг баттай хангах үйл явцтай. i. Аюулгүй зан үйл ба ажлын дадлыг дэмжих, аюулгүй байдлын байнгын шалгалт, зааварчилгааг бий болгох явдлыг хангах сургалтыг дэмжих ба бататгахын тулд хэрэгжүүлдэг биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндэд зориулсан ажиглалтын хөтөлбөртөй. j. Сургалтыг дэмжих ба бататгахын тулд хэрэгжүүлдэг сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлд зориулсан ажиглалт ба оролцооны хөтөлбөртөй. k. Уурхай нь эрүүл мэнд, аюулгүй байдал ба хүндлэлтэй ажлын байрны зорилтуудыг тодорхойлох, мөн аюул илрүүлэх, эрсдэл үнэлэх ба хяналт тодорхойлоход ажилчдын оролцоог хангах механизмтай. 2. Сургалт болон мэдлэг олгох хөтөлбөрт урьдчлан сэргийлэх болон идэвхтэй арга хэмжээнд төвлөрсөн аюул илрүүлэх ба хяналт тодорхойлох асуудлыг тусгана. Энэ нь нийгэм-сэтгэл санааны болон биеийн аюулыг авч үзвэл зохих ба эдгээр асуудлыг шийдвэрлэх дотоод болон гадаад механизмаар хангана
---	--

АА	- Уурхай нь аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны шалгуурыг бизнесийн үндсэн үйл явц ба дадалд нэгтгэх замаар байгууллагын оролцоог дэмжих ба үүнд доорх зүйлс багтана: - Жил тутмын бизнесийн стратеги ба үйл ажиллагааны төлөвлөгөө. - Худалдан авалтын шийдвэрүүд. - Гүйцэтгэлийн үнэлгээний үйл явц. - Нөхөх олговрын систем (ө.х., аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийн нөлөөнөөс үүдэлтэй нөхөх олговор). - Биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэл ба хүртээмжийг эрхэмлэдэг ажлын байрны төлөвлөлт ба соёлд зориулсан заавар хэрэгжүүлдэг.
ААА	- Аюулгүй, эрүүл ба хүндлэл бүхий ажлын байрны талаарх үүрэг амлалт нийт уурхайн хэмжээнд нэвтэрсэн нь илт харагдана. - Уурхайн удирдлага нь ажилтнуудтай харилцахдаа эрүүл, аюулгүй, хүндлэлтэй зан үйл ба соёлыг илт үлгэрлэдэг нь харагдана. - Сургалтын хөтөлбөрийн үр дүнтэй нөлөөнд мониторинг хийх ба үнэлэх үйл явцтай.

Түгээмэл асуултууд: Сургалт, зан үйл ба соёл

#	Түгээмэл асуултууд
10	“Тогтолцоо” гэж юуг хэлэх вэ?
11	“Үр нөлөөтэй” гэж юуг хэлэх вэ?
19	“Ажиглалтын хөтөлбөр” гэж юуг хэлэх вэ?
20	“Нөхөн олговор” гэж юуг хэлэх вэ?
24	Уурхайн түвшний үүрэг амлалтыг компанийн түвшний баримт бичгийг ашиглан нотлон харуулж болох уу?
37	Компани нь сургагч нарынхаа чадамж ба үр нөлөөг үнэлдэг гэдгээ хэрхэн нотлон харуулж болох вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 5: МОНИТОРИНГ БА ТАЙЛАГНАЛ

Зорилго

Биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлд байнга мониторинг хийж, дотоод болон гадагш тайлагнадаг гэдгийг нотлох.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Уурхай нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	1. Хууль тогтомжийн шаардлагаас давсан, сургалт ба аюулгүй байдал, эрүүл мэндийн зарим үндсэн хэмжүүрүүдэд байнгын мониторинг хийж, уурхайн удирдлагад тайлагнадаг 2. Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг уурхай дотроо мэдээлдэг эсвэл байршуулдаг. 3. Уурхай нь А түвшний бүх шаардлагыг биелүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан.

А	1. Биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал ба эрүүл мэндэд мониторинг хийж, тайлагнаж баримтжуулдаг. Үүнд дараах зүйлс багтана: a. Гүйцэтгэлийн хэмжүүрийг ойлгомжтой тодорхойлсон, тууштай хэрэглэдэг, байнга үнэлж (мөн салбарын нийтлэг гүйцэтгэлтэй харьцуулан), дотооддоо тайлагнадаг. b. Гүйцэтгэлийн хэмжүүрийг шийдвэр мэдээлэх чиг хандлагыг шинжлэх болон байнгын сайжруулалтыг чиглүүлэхэд ашигладаг. c. Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлт зан үйлийн талаар мэдээлэгдсэн асуудлын тоо болон төрлийн талаарх өгөгдөл цуглуулдаг, түүнд байнга мониторинг ба шинжилгээ хийдэг. d. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн мониторингийн хөтөлбөртөй. Үүнд: давах ба хоцрох үзүүлэлтүүдийг мөшгөх ба дотооддоо мэдээлэх, мөн аюулгүй байдал ба эрүүл мэнд болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйн үзлэг шалгалт ба мониторинг хийх, эрүүл мэндийн тандалт ба тааламжгүй тохиолдолыг судлах түүний мөрөөр авах арга хэмжээ багтана. e. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн аудитын хөтөлбөр хөтөлбөртөй, нийцлийн аудит болон менежментийн тогтолцооны аудитыг аудитын төлөвлөгөөний дагуу хийдэг. f. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн мониторинг болон аудитын хөтөлбөр нь үр дагавар ихтэй аюул дээр төвлөрдөг. g. Уурхай нь аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны зохистой ба үр нөлөөтэй байдалд жил бүр үнэлгээ хийж, сайжруулах зөвлөмж гаргадаг. h. Байнга сайжруулах ба шийдвэр гаргахад мэдээллээр хангах зорилгоор биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлд удирдлагын дүн шинжилгээ тогтмол хийдэг. i. Ажлын байрны мониторинг ба үзлэг шалгалтын үр дүн, түүний мөрөөр авсан арга хэмжээг бүртгэж, уурхай дотроо мэдээлж харилцдаг. j. Биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийг жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд мэдээлж харилцдаг.
---	---

AA	1. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн өгөгдөл, мэдээлэл цуглуулах, эмхэтгэх ба тайлагнах үйл ажиллагаа нь А түвшний шаардлагуудыг хангасан эсэхэд дотоод аудит хийсэн. 2. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн эгзэгийн хяналтын гүйцэтгэлд хамаарах босго ба өдөөгчийн утгуудыг боловсруулж, хэрэгжүүлж байгаа, зарим босго ба өдөөгчийн утга аль хэдийн бий болсон. 3. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн мониторинг ба аудитын хөтөлбөр нь эгзэгийн хяналтад төвлөрдөг. 4. Уурхай нь хүндлэлтэй ажлын байртай холбоотой хариу арга хэмжээ, шийдвэрлэх ба/эсвэл засч залруулах талаар нэгтгэсэн болон нэрээ нууцалсан мэдээлэл болон уурхайн хариу өгөх механизмд мэдээлсэн сэтгэл санааны аюулгүй байдлын асуудлуудад шинжилгээ хийдэг, мөн явцын мониторинг ба шинжилгээ хийдэг
AAA	1. Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн өгөгдөл, мэдээлэл цуглуулах, эмхэтгэх ба тайлагнах үйл ажиллагаа нь А түвшний шаардлагуудыг хангасан эсэхэд гадаад аудит хийсэн. 2. Үр нөлөөний дотоод үнэлгээ хийж, гаргасан сайжруулах боломжуудыг мөшгөх үйл явцтай. Үүнд хийсэн судалгаа ба арга хэмжээний хаалтын чанарын дотоодын үнэлгээ багтах ба энэ нь байнгын сайжруулалт хийх соёлд нэмэр оруулдаг.

Түгээмэл асуултууд: Мониторинг ба тайлагнал

#	Түгээмэл асуултууд
10	“Тогтолцоо” гэж юуг хэлэх вэ?
11	“Үр нөлөө” гэж юу хэлэх вэ?
21	“Эрүүл мэндийн магадлах хяналт” гэж юуг хэлэх вэ?
22	“Ажлын байрны мониторинг” гэж юуг хэлэх вэ?
23	“Босго” ба “шийдвэрийн” цэг гэж юуг хэлэх вэ?
24	Уурхайн түвшний үүрэг амлалтыг нотлон харуулахын тулд компанийн түвшний баримт бичгийг ашиглаж болох уу?
38	Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйлийг салбарын нийтлэг гүйцэтгэлтэй хэрхэн харьцуулан үнэлэх вэ?
39	Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийн гүйцэтгэлийн талаар уурхай ямар мэдээлэл тайлагнаж болох вэ?
42	“Аудит” гэж юуг хэлэх вэ?
43	Компани эсвэл уурхай нь AA түвшний дотоод аудит хийхгүйгээр гадаад аудитыг амжилттай хийлгэснээр AAA түвшинг хангаж болох уу?
44	Дотоод болон гадаад аудит ямар хугацаанд хүчинтэй байх вэ?

ҮЗҮҮЛЭЛТ 6: БИЕИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Зорилго

Бүх уурхайн зорилго нь аюул тэглэх явдал гэж ухамсарлах үед энэ үзүүлэлтийн зорилго бол уурхай тус бүр биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийг байнга сайжруулах зорилтуудыг тодорхойлж эдгээр зорилтуудын биелэлтэд үнэлгээ хийдгийг нотлох.

Хэрэв уурхайд тухайн тайлангийн жилд хүний амь нас эрсдсэн осол гарсан бол А эсвэл үүнээс дээш түвшнийг хангах боломжгүй гэж үзнэ.

Үнэлгээний шалгуур:

Түвшин	Шалгуур
С	Уурхай нь В түвшний бүх шалгуурыг хангаагүй.
В	- Уурхайн ажилтнуудын хувьд биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийн зорилтууд тогтоосон. - Зорилтуудын талаар ажилтнуудад мэдээлж харилцдаг. - Уурхай нь А түвшний бүх шаардлагыг хангахын тулд арга төлөвлөгөө боловсруулсан.
А	- Гүйцэтгэлийн зорилтууд нь уурхай дээрх гэрээлэгч нарт хамаардаг. - Уурхайн удирдлага нь зорилтуудын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх ба сайжруулахад сайжруулахад оролцдог. - Гүйцэтгэлийн үр дүнг ажилтнууд болон уурхай дээрх гэрээлэгч нарт мэдээлж харилцдаг. - Уурхай дээр тайлангийн жилд хүний амь нас эрсдсэн осол гараагүй.
АА	- Гүйцэтгэлийн зорилтуудыг давах ба хоцрох үзүүлэлтүүдийн аль алин дээр тогтоосон. - Дээд удирдлага уурхайн зорилт ба холбогдох сайжруулах төлөвлөгөөний гүйцэтгэлд дүн шинжилгээ хийдэг. - Уурхай (эсвэл компани) нь биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийг ижил төстэй уурхай (эсвэл компани)-тай жишиж үздэг.
ААА	- Уурхай нь байнга сайжруулах гүйцэтгэлийн зорилтуудыг тууштай (сүүлийн 4 жилийн 3 жилд нь) биелүүлсэн бөгөөд 4 жилийн хугацаанд хүний амь нас эрсдсэн осол гараагүй. - Уурхай нь биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийн үнэн бодит, найдвартай байдлыг хангах зорилгоор гадаад аудит хийлгэсэн.

Түгээмэл асуултууд: Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэл

#	Түгээмэл асуултууд
3	“Дээд удирдлага” гэж юуг хэлэх вэ?
24	Уурхайн түвшний үүрэг амлалтыг нотлон харуулахын тулд компанийн түвшний баримт бичгийг ашиглаж болох уу?
40	Жишиж үзэхэд ямар түвшин зохимжтой вэ?
41	Хүний амь эрсдэх нь 6 дугаар үзүүлэлтийн хувьд уурхай А түвшинг хангахад саад болох уу?
42	“Аудит” гэж юуг хэлэх вэ?
43	Компани эсвэл уурхай нь АА түвшний дотоод аудит хийхгүйгээр гадаад аудитыг амжилттай хийлгэснээр ААА түвшинг хангаж болох уу?
44	Дотоод болон гадаад аудит ямар хугацаанд хүчинтэй байх вэ?

Хавсралт 1: Түгээмэл асуултууд

Түгээмэл асуултууд (Frequently Asked Questions) гэдэг нь ТУУТ стандартын протоколын дагуу өөрийн үнэлгээ ба хөндлөнгийн шалгалт хийлгэхэд заавал биелүүлэх бүрэлдэхүүн хэсэг юм. Протоколд заасан шалгуурыг зохих ёсоор тайлбарлах ба хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхийн тулд уурхай нь доор дурдсан тодорхойлолт/тайлбарууд/ ба удирдамжид дүн шинжилгээ хийж дагаж мөрдөх ёстой.

ТОДОРХОЙЛОЛТУУД /ТАЙЛБАРУУД/

1. “Ажлын байр” гэж юуг ойлгох вэ?

Ажлын байрны талаар хэрэглэж болохуйц хэд хэдэн тодорхойлолт байдаг. Жишээ нь, Ажлын байран дахь сэтгэл санааны эрүүл мэнд байдлын тухай, аюулгүй байдлын тухай Канад улсын үндэсний стандартад:

«Ажилчин аль нэг байгууллагад ажилладаг эсвэл байгууллагын нэрийн өмнөөс үйлчилгээнд оролцож байхдаа (нийгмийн арга хэмжээг оролцуулан) байгууллагын нэрийн өмнөөс байхыг шаардсан эсвэл зөвшөөрсөн газар эсвэл байршил.» гэж тодорхойлсон

Австралийн засгийн газрын агентлаг (Safe Work Australia) ажлын байр гэдгийг :

“Ажил эсвэл үүрэг гүйцэтгэх аливаа газар, ажиллах үедээ очдог эсвэл очих магадлалтай газар үүнд орно. Үүнд оффис, үйлдвэр, дэлгүүр, барилгын талбай, тээврийн хэрэгсэл, усан онгоц, нисэх онгоц эсвэл газар эсвэл усан дээрх бусад хөдөлгөөнт байгууламжууд орж болно» гэж тодорхойлсон

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү:

CAN/CSA-Z1003-13/BNQ 9700-803/2013 – Ажлын байран дээрх сэтгэл санааны эрүүл мэнд ба аюулгүй байдал (Psychological Health and Safety in the Workplace). <https://www.csagroup.org/article/canca-z1003-13-bnq-9700-803-2013-r2018/>

Safe Work Australia. n.d. А Нийтлэг ба нийлмэл нэр томъёо ба тодорхойлолтууд (Glossary of common and complex terms and their definitions). <https://www.safeworkaustralia.gov.au/glossary>

2. “Хүндлэлтэй ажлын байр” гэж юуг хэлэх вэ?

“Хүндлэлтэй ажлын байр” гэдэг нь хүчирхийлэл, дээрэлхэлт, гадуурхал дарамт зэрэг гэмт зан үйлээс ангид ажлын байрыг хэлнэ.

Жишээ нь Бритиш Колумби мужийн Засгийн газар хүндлэлтэй ажлын байрыг дараах байдлаар тодорхойлдог:

... шударга, үнэнч, хамтач ба мэргэшсэн байдал хэм хэмжээ болсон ажлын байр.

Хүндлэлтэй ажлын байр нь:

- Оролцоотой
- Олон талт байдлыг эрхэмлэдэг
- Зан үйлтэй холбоотой хүлээлтийн талаар тодорхой мэдээлж харилцдаг
- Ажилтны эрүүл мэнд ба аюулгүй байдлыг дэмждэг
- Маргаан шийдэх нөөц ба сургалтаар хангадаг
- Сайжруулах эрмэлзэлтэй
- Мэдээлэл харилцааны нээлттэй сувагтай.

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү: Бритиш Колумбия мужийн Засгийн газар (*Government of British Columbia*). 2021. Ажлын байран дээр хүндлэлийг ийг бүрдүүлэх нь (*Promote respect in the workplace*).

<https://www2.gov.bc.ca/gov/content/careers-myhr/all-employees/working-with-others/promote-respect>

3. “Дээд удирдлага” гэж юуг хэлэх вэ?

Аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийн үнэлгээний хувьд дээд удирдлага гэж уурхайн түвшний хамгийн дээд удирдах албан тушаалыг (жишээ нь Ерөнхий менежер, Уурхайн менежер/дарга гэх мэт) хэлнэ. Протоколд аюулгүй байдал ба эрүүл мэндийн эгэх хариуцлагыг бүх түвшинд оногдуулахыг шаардаж байгаа бол уурхай, бизнесийн нэгж, бүс нутаг эсвэл компанийн түвшинд (компанийн бүтэц, төв албаны байршил зэргээс хамаарна) эгэх хариуцлагыг оногдуулна гэж ойлгоно. Компани ассоциациар дамжуулан ТУУТ стандартын протоколыг хэрэгжүүлж байгаа бол энэхүү шаардлагыг шалгахын тулд тус улсын гадна байрладаг төв оффисыг хамруулахыг шаардахгүй.

4. “Эгэх хариуцлага” гэж юуг хэлэх вэ?

Эгэх хариуцлага гэж аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоо нь уурхай дээр аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоог боловсруулах ба нэвтрүүлэх болон аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийг эцсийн эцэст хариуцах талыг тодорхойлохыг хэлнэ. Эгэх хариуцлагыг шилжүүлж болохгүй. Аюулгүй байдал ба эрүүл мэндийн зорилтоо үр нөлөөтэй биелүүлэхийн тулд зохих тогтолцоог (*сургалт, тоног төхөөрөмж, мэдээлэл харилцаа гэх мэт*) бүрдүүлэх зориулсан нөөцөөр эгэх хариуцлага хүлээсэн этгээдийг хангана

5. “Үүрэг хариуцлага” гэж юуг хэлэх вэ?

Үүрэг хариуцлага гэж аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны хүрээнд аюулгүй байдал ба эрүүл мэндтэй холбоотой тодорхой шаардлага ба ажил үүргийг тодорхойлж, уурхайн доторх тодорхой албан тушаалд тохоон хуваарилахыг хэлнэ. Үүрэг хариуцлагын талаар тодорхой мэдээлж харилцах нь чухал ба ингэснээр албан тушаал бүр дээр тэднээс юу хүлээж байгааг сайтар ойлгох боломжтой.

6. “Аюул илрүүлэх ба эрсдэл үнэлэх (АИЭҮ) гэж юуг хэлэх вэ?

Аюул илрүүлэх ба эрсдэл үнэлэх (АИЭҮ) гэж нь аюулгүй байдал ба эрүүл мэндтэй бүхий л аюулыг илрүүлж, эрсдэлийн түвшинг үнэлж, эрсдэлийг удирдах хяналт тогтоосон баримтжуулсан үйл явц юм. Аюул илрүүлэх ба эрсдэл үнэлэх (АИЭҮ) нийтлэг үйл явцад дараах багтдаг:

- Уурхай дээрх судалгаа.
- Хяналтын шатлал.
- Эрсдэлийн бүртгэл.
- Аюул ба Ажиллах чадвар (HAZOP) ба Аюулаас сэргийлэх (Failsafe) үйл явц
- Өөрчлөлтийн менежмент.
- Ажлын байрны аюулгүй байдлын шинжилгээ.
- Талбай дахь эрсдэлийн үнэлгээ (эсвэл ижил төстэй үнэлгээ).
- Мэргэжлээс шалтгаалах өвчин эсвэл эрүүл мэндэд нөлөөлөх гэмтэл хүргэх үр дагавартай тохиолдолыг илрүүлэх.

Уурхай дээр “аюул илрүүлэх ба эрсдэл үнэлэх болон хянах” үйл явц бий болсоныг нотлон харуулахын тулд аюул илрүүлэх, эрсдэл үнэлэх болон тохирох хяналт тогтоох үйл явцыг уурхай баримтжуулсан байх ёстой. Аюулыг авч үзэхийн тулд эрсдэлийн баримтжуулсан эсвэл цахим бүртгэл нь уурхай дээрх аюул илрүүлэх ба хяналт тодорхойлох бөгөөд уурхай нь өөрийн түвшинд хэрэглэж болох эрсдэлийн үнэлгээний арга хэрэгсэл эсвэл үйл явцтай байна. Аюул илрүүлэх ба эрсдэл үнэлэхийг үндсэндээ биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн агуулгаар хэрэглэдэг боловч энэ бүтцийг сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй ажлын байр дээр ч хэрэглэж болно.

7. “Хяналт” гэж юуг хэлэх вэ?

Энэ нэр томъёонд хүсээгүй үйл явдлаас сэргийлэх, зайлсхийх эсвэл хүсээгүй үйл явдлын үр дагаврыг бууруулах, арилгах зорилготой үйлдэл, объект (зохион бүтээсэн) эсвэл тогтолцоо (үйлдэл ба объектын хослол)-г хамруулж ойлгоно.

Дэлгэрэнгүй мэдээлэл: Олон улсын ашигт малтмал, металлын зөвлөл (ICMM). 2015. Аюулгүй байдал ба эрүүл мэндийн эгзэгтэй цэгийн хяналтын менежмент (Health and Safety Critical Control Management). <http://www.icmm.com/website/publications/pdfs/health-and-safety/8570.pdf>

8. “Мэргэшсэн эрүүл ахуйч” гэж юуг хэлэх вэ?

Үзүүлэлт 2-н хувьд АА түвшнийг хангахын тулд үйлдвэрийн эрүүл ахуйн эрсдэл ба хяналтад мэргэшсэн эрүүл ахуйч дүн шинжилгээ хийдэг гэдгийг уурхай нотлон харуулах ёстой. Үзүүлэлт 2-н хувьд АА түвшнийг хангахын тулд үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөрийг мэргэшсэн эрүүл ахуйч хянадаг гэдгийг уурхай нотлон харуулан ёстой. Дээр дурдсан дүн шинжилгээ ба хяналтыг мэдлэг, сургалт ба/эсвэл туршлагад үндэслэн мэргэшсэн хүнөөрөө эсвэл тийм хүний улидлагадор хүлээн зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн эрүүл ахуйн дадалд нийцүүлэн хийж гүйцэтгэнэ.

9. “Төлөвлөлт” гэж юуг хэлэх вэ?

Төлөвлөлт гэдэгт аюул илрүүлэх, эрсдэл үнэлэх, хяналт тодорхойлох; хэрэглэх хууль тогтоомжийн шаардлагыг тодорхойлох, тэдгээрт нэвтрэх; болон уурхайн холбогдох чиг үүрэг ба түвшинд баримтжуулсан зорилтууд ба дэмжих хөтөлбөрүүдийг бий болгох, хэрэгжүүлэх үйл ажиллагаа орно (OHSAS 18001:2007-д нийцсэн)

10. “Тогтолцоо” гэж юуг хэлэх вэ?

Тогтолцоо эсвэл менежментийн тогтолцоо гэж тодорхой үр дүнд хүрэх болон гүйцэтгэлийг байнга сайжруулахын тулд ажлыг зөв, тууштай, үр нөлөөтэй гүйцэтгэхэд зориулсан цэгцтэй бүтцээр хамтдаа хангадаг үйл явцуудыг хэлнэ.

Менежментийн тогтолцооны арга нь юу хийх шаардлагатайг үнэлэх, зорилтын биелэлт төлөвлөх, төлөвлөгөөний биелэлт ба тавьсан зорилтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхийг шаарддаг. Менежментийн тогтолцоо нь мөн хэрэгцээт ажилтан, нөөц болон баримтжуулалтын шаардлагыг авч үздэг. Тогтолцоонд хамаатай бусад тодорхойлолтуудыг доор харуулав:

Бодлого: Тодорхой асуудлын талаар компанийн байр суурийг сонирхогч гадаад талуудад танилцуудаг удирдлагын үүрэг амлалтын илэрхийлэл.

Дадал: Ажил гүйцэтгэх албан бус баримтжуулаагүй арга барил.

Заавар: Ажил хэрхэн гүйцэтгэх тухай баримтжуулсан тайлбар.

11. “Үр нөлөө” гэж юуг хэлэх вэ?

Үр нөлөө гэдэг нэр томъёог хэрэглэж байгаа бол энэ нь хүссэн үр дүнд хүрэхийн тулд элемент ажиллаж байгаа гэсэн үг.

12. “Эгзэгийн хяналт”, “зайлсхийх хяналт” болон “энгийн хяналт” гэж юу вэ?

Түгээмэл асуултын 7-д дурдсанчлан хяналт гэж хүсээгүй үйл явдлаас сэргийлэх, зайлсхийх эсвэл хүсээгүй үйл явдлын үр дагаврыг бууруулах, арилгах зорилготой үйлдэл, объект (зохион бүтээсэн) эсвэл тогтолцоо (үйлдэл ба объектын хослол)-г хэлнэ.

Эгзэгийн хяналт нь хүсээгүй бодит үйл явдлаас учрах үр дагавраас сэргийлэх эсвэл зайлсхийхэд чухал ач холбогдолтой. Бусад төрлийн хяналт байсан ч эгзэгийн хяналт байхгүй эсвэл бүтэлгүйтэх нь эрсдэлийг ихээхэн нэмэгдүүлэх болно. Нэгээс олон хүсээгүй үйл явдлаас сэргийлэх эсвэл нэгээс олон үр дагаврыг зайлсхийх хяналтыг ихэвчлэн эгзэгийн ангилалд оруулдаг. Эгзэгийн зайлсхийх хяналт нь хүсээгүй бодит үйл явдлын үр дагаврыг арилгадаг эсвэл хүлцэхүйц босго хүртэл бууруулдаг.

Хүсээгүй үйл явдлын үр дагаврыг арилгах эсвэл бууруулах хяналт нь зайлсхийх хяналт юм.

Энгийн хяналт гэдэг нь эгзэгийн биш (жишээ нь, хүсээгүй үйл явдалд шууд саад учруулахгүй) боловч эгзэгийн хяналтын үр нөлөөг хадгалах эсвэл дэмжихэд чухал ач холбогдолтой үйл ажиллагаа эсвэл механизм юм.

Үүнд сургалтын тогтолцоо, мониторингийн үйл ажиллагаа эсвэл ажиллагааны болон хариу өгөх төлөвлөгөө багтаж болно.

Энэ нь эгзэгийн хяналтад шаардагдах үзлэг шалгалт хийхийг дэмждэг, мөн эгзэгтэй хяналтын төлөв байдлыг шалгахад мэдээллээр хангах боломжтой менежментийн тогтолцооны үйл ажиллагааг багтааж болох өргөн хүрээний ангилал юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү: Олон улсын ашигт малтмал, металлын зөвлөл (ICMM). 2015. аюулгүй байдал ба эрүүл мэндийн эгзэгтэй цэгийн хяналтын менежмент (Health and Safety Critical Control Management). <http://www.icmm.com/website/publications/pdfs/health-and-safety/8570.pdf>

Олон улсын ашигт малтмал, металлын зөвлөл (ICMM). 2015. Эгзэгтэй цэгийн хяналтыг хэрэгжүүлэх зааварчилгаа (Critical Control Management Implementation Guide). <http://www.icmm.com/website/publications/pdfs/health-and-safety/8570.pdf>

13. “Эрвээхэй зангианы шинжилгээ” гэж юуг хэлэх ?

Эрвээхэй зангианы шинжилгээ (ЭЗШ) гэж хүсээгүй тодорхой үйл явдлаас сэргийлэх, зайлсхийх зорилготой хяналтыг тодорхойлох ба дүн шинжилгээ хийх шинжилгээний арга юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү: Олон улсын ашигт малтмал, металлын зөвлөл (ICMM). 2015. аюулгүй байдал ба эрүүл мэндийн эгзэгтэй цэгийн хяналтын менежмент (Health and Safety Critical Control Management) <http://www.icmm.com/website/publications/pdfs/health-and-safety/8570.pdf>

14. “Сэтгэл санааны аюулгүй байдал” болон “Сэтгэл санааны эрүүл мэнд ба аюулгүй байдал” хоорондын ялгаа юу вэ?

“Сэтгэл санааны аюулгүй байдлын 4 үе шат: Хүртээмж ба инновацад хүрэх арга замыг тодорхойлох нь”

Тимоти Кларк сэтгэл санааны аюулгүй байдлын 4 үе шатыг тодорхойлсон: энэ нь хувь хүмүүс мэдрэх дараах нөхцөл бүрдүүлнэ: 1) оролцоход аюулгүй, 2) суралцахад аюулгүй, 3) хувь нэмрээ оруулахад аюулгүй, болон 4) бие даасан байдалд аюулгүй.

Сэтгэл санааны аюулгүй байдлын үндэс болох “оролцооны аюулгүй байдал” нь ТУУТС-н Тэгш, олон янз, оролцоотой ажлын байрны протоколтой нягт холбоотой.

Канад улсын Ажлын байрны сэтгэл санааны аюулгүй байдал ба эрүүл мэндийн үндэсний стандартад “сэтгэл санааны аюулгүй байдал”-г ажилчдын сэтгэцийн тайван байдалд учирч болох хохирол/эсвэл хохирол учруулах занал байхгүй нөхцөл” хэмээн тодорхойлж, улмаар “ажлын орчинд сэтгэл санааны аюулгүй байдлыг сайжруулах гэдэг нь ажилчдын сэтгэцийн эрүүл мэндэд гэмтэл эсвэл хохирол учруулахаас сэргийлэхийг хэлнэ ” гэж нэмж тайлбарласан.

Мөн сэтгэл санааны хувьд эрүүл ба аюулгүй ажлын байрыг “Ажилчдын сэтгэл санааны тайван байдлыг төлөвшүүлж, ажилчдын сэтгэл санааны эрүүл мэндэд учрах хохиролоос, үүнд хайхрамжгүй, болгоомжгүй эсвэл санаатай учруулах хохирол багтана, сэргийлэхийн тулд идэвхитэй ажилладаг ажлын байр” гэж тодорхойлсон.

Нийгэм-сэтгэл санааны эрсдэлийн хүчин зүйлсийг “ажиллах орчин, менежмент, дадал ба/ эсвэл зохион байгуулалтын асуудал зэрэг эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлдэг аюул” гэж тодорхойлсон.

Сэтгэл санааны аюулгүй байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл:

CAN/CSA-Z1003-13/BNQ 9700-803/2013 – Ажлын байран дээр сэтгэл санааны эрүүл мэнд, аюулгүй байдал (Psychological Health and Safety in the Workplace). <https://www.csagroup.org/article/can-1003-13-bnq-9700-803-2013-r2018/>

Канад улсын Ажлын байрны аюулгүй байдал ба эрүүл мэндийн төв (Canadian Centre for Occupational Health and Safety). 2023. Ажил олгогч нарт зориулсан сэтгэл санааны эрүүл мэнд, аюулгүй байдал (Psychological Health and Safety for Employers). <https://www.ccohs.ca/products/courses/phs-employers/>

ISO 45003:2021 Ажлын байрны аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежмент- Ажил дээрх сэтгэл санааны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа-сэтгэл санааны эрсдэлийг удирдах гарын авлага (ISO 45003:2021 Occupational health and safety management — Psychological health and safety at work — Guidelines for managing psychosocial risks). <https://www.iso.org/standard/64283.html>

Тимоти Кларк (Timothy R. Clark). 2020. сэтгэл санааны аюулгүй ажиллагааны 4 шат: Хүртээмж болон инновацад хүрэх арга замыг тодорхойлох нь (The 4 Stages of Psychological Safety: Defining the Path to Inclusion and Innovation. Berrett-Koehler Publishers, Inc).

15. “Нийгэм-сэтгэл санааны аюул” гэж юуг хэлэх вэ?

Австралийн Викториа мужийн Аюулгүй ажиллагааны агентлагийн тодорхойлсноор “нийгэм-сэтгэл санааны аюул гэдэг нь ажилтай хобоотой стрессийн эрсдэлийг нэмэгдүүлж, сэтгэл санааны эсвэл биеийн хохирол учруулж болзошгүй ажлын байрны төлөвлөлт эсвэл менежментийн хүчин зүйлс” юм. Нийгэм-сэтгэл санааны аюулын биет нөлөөлөлд осол ба гэмтлийн нэмэгдсэн түвшин, эсвэл хамтран ажиллагсад эсвэл дотоод ба гадаад ажлын байрны эсрэг биет хүчирхийлэл эсвэл дарамт орж болно. Баруун Австрали мужийн Уул уурхай, аж үйлдвэрийг зохицуулалтын яамны зүгээс “стресс, ядаргаа, дээрэлхэлт, хүчирхийлэл, түрэмгийлэл, дарамт, сульдалт зэрэг ажилчдын эрүүл мэндэд хортой бөгөөд тэдний тайван байдалыг нь түйвээх зүйлс” үүнд багтдаг гэж үзсэн.

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү: Викториа мужийн аюулгүй ажиллагааны төв (WorkSafe Victoria). 2022. Ажлын хамааралтай стрессийг үүсгэгч нийгэм-сэтгэл санааны аюулууд (Psychosocial hazards contributing to work-related stress). <https://www.worksafe.vic.gov.au/psychosocial-hazards-contributing-work-related-stress>

Австрали улсын Засгийн газар (Australian Government Comcare). 2022. Нийгэм-сэтгэл санааны аюул (Psychosocial hazards). <https://www.comcare.gov.au/safe-healthy-work/prevent-harm/psychosocial-hazards>

Австрали улсын аюулгүй ажиллагааны байгууллага (Safe Work Australia). n.d. Нийгэм-сэтгэл санааны аюул (Psychosocial hazards). <https://www.safeworkaustralia.gov.au/safety-topic/managing-health-and-safety/mental-health/psychosocial-hazards>

Баруун Австрали мужийн Уул уурхай, аж үйлдвэрийг зохицуулалтын яам (Government of Western Australia Department of Mines, Industry Regulation and Safety).

n.d. сэтгэл санааны аюулын тойм (Psychosocial hazards overview). <https://www.dmp.wa.gov.au/Safety/Psychosocial-hazards-overview-25390.aspx>

Канадын Ажлын байрны аюулгүй байдал ба эрүүл мэндийн төв (Canadian Centre for Occupational Health and Safety). 2022. Яс булчингийн гэмтэл- Нийгэм сэтгэл санааны хүчин зүйлс (Musculoskeletal Disorders

- Psychosocial Factors). <https://www.ccohs.ca/oshanswers/psychosocial/musculoskeletal.html>

Оюун санаагаа хамгаалах нь (Guarding Minds) @ Work. 2020. Нийгэм сэтгэл санааны хүчин зүйлсийг мэдэх нь (Know the Psychosocial Factors). <https://www.guardingmindsatwork.ca/about/about-psychosocial-factors>

16. “Гэмтэл-мэдээлэл” гэж юу гэсэн үг вэ?

Австралийн Эрдэс баялгийн зөвлөл нь бэлгийн дарамт ба хүчирхийлэлийн эсрэг үзүүлэх хариу өгөх агуулгын хувьд гэмтэл-мэдээллийн тусламж ба дадлын талаар чухал удирдамж гаргасан. Товчхондоо энэ нь албан бус болон албан ёсны хариу өгөх механизмаар дамжуулан тавьсан асуудалд хариу өгөхдөө нөлөөлөлд өртсөн хувь хүн, бүлгүүд болон бусад холбогдох хүмүүсийн биеийн, сэтгэл санааны болон сэтгэл сэтгэл хөдлөлийн аюулгүй байдлыг чухалчилдаг гэсэн үг.

Австралийн эрдэс баялгийн зөвлөл (Minerals Council of Australia). 2021. Бэлгийн дарамтын хохирогчид хэрхэн дэмжлэг үзүүлэх вэ- гэмтэлд суурилсан эмчилгээ (How to support persons affected by sexual harassment – trauma informed care).

https://www.minerals.org.au/sites/default/files/Respect%40Work_Guidance%20-%20How%20to%20support%20affected%20persons%20-%20trauma%20informed%20care.pdf

17. “Гэмт зан үйл” гэж юуг хэлэх вэ?

Австралийн засгийн газрын агентлаг(Safe Work Australia) “Гэмт зан үйл нь түүнийг чиглүүлсэн хүнд, мөн уг зан үйлийг харсан хэн бүхэнд хохирол учруулж болзошгүй юм” гэж тодорхойлсон ба үүнд дараах зүйлс орно:

- Хүчирхийлэл ба түрэмгийлэл
- Дээрэлхэлт
- Дарамт, үүнд бэлгийн болон хүйсийн дарамт, арьсны өнгөөр, тусгай хэрэгцээгээр, насаар ялгаварлах нь мөн багтана
- Ажлын байран дахь зөрчил, таарамжгүй харьцаа ба харилцаа.

18. “Ажиглалтын хөтөлбөр” гэж юу вэ?

Ажиглалтын хөтөлбөр нь төвлөрч буй талбараас хамааран өөр өөр элементүүдтэй байж болно.

Жишээ нь ажил ба ажлын байрны ажиглалт нь аюултай байдал эсвэл аюултай үйлдэл ба нөхцлийг арилгахад тусална. Эдгээрийг нийт ажиллах хүчний оролцоог идэвхитэй дэмжиж явуулах ба ингэснээр аюулгүй байдлын талаарх мэдлэг ойлголтыг хувь хүн болон хамт олонд түлхүү бий болгоно. Энэ нь үндсэндээ нийт ажилчдын оролцоог ханган удирдлагын зохион байгуулалт ба хяналт дор хийдэг үйл явц юм. Ажиглалтийн үйл явц нь үндсэн дөрвөн алхамаас:

1. Ажиглалтын төлөвлөгөө гаргах.
2. Ажиглалт хийж гүйцэтгэх.
3. Ажилчдад зохистой санал зөвлөмж өгөх эсвэл дахин зааварчилгаа өгөх.
4. Ажлыг эрүүл ба аюулгүй байдлаар үргэлжлүүлэн гүйцэтгэх үүрэг амлалтыг эрэлхийлэх.

Ажиглалтын үйл явцыг ашиглан аюул илрүүлэх, эрсдэл үнэлэх хөтөлбөрүүд, түүнчлэн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны (жишээ нь талбайн түвшний эрсдэлийн үнэлгээ, зааврууд, сургалт, дүрэм болон стандарт, аюулын судалгааны үр дүн) үр нөлөөг шалгахад ашиглаж болно.

Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлт зан үйлийн тодорхой сэдвүүдийн хувьд ажиглалтын хөтөлбөр нь удирдах ажилтнууд хэрхэн ажилтнуудтай болон ажиллагсад хэрхэн бие биетэйгээ харьцдаг, түүнчлэн манлайлал, ажиглагдсан зан үйлийг сайжруулах боломж зэргийг авч үзэж болно.

19. “Нөхөн олговор/ урамшуулал” гэж юуг хэлэх вэ?

Нөхөн олговор гэж ажилтнуудад буцаан олгож буй нийт багцыг хэлнэ.

20. “Эрүүл мэндийн магадлах хяналт” гэж юуг хэлэх вэ?

Ажлын байрны эрүүл мэндийн магадлах хяналт гэж сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай мэргэжлээс шалтгаалсан өртөлтийг тодорхойлох зорилготой эрүүл мэндийн мэдээллийн шинжилгээг хэлнэ. Магадлах хяналт нь ажил олгогчтой харьцах холбоос болж ажилладаг. Эрүүл мэндийн байдлын хэвийн бус хандлагыг олж тогтоохын тулд магадлах хяналт нь бүлэг эсвэл нэг ажилтаны үзлэгийн үр дүнг ашигладаг. Бүлгийн үр дүнд дүн шинжилгээ хийх нь болзошгүй өртөлтийн асуудлыг тогтооход, мөн ажлын байран дээр хэрэгжиж буй хяналт, урьдчилан сэргийлэх хяналтын үр дүнтэй байдлыг үнэлэхэд хэрэглэж болно. Ажилтнуудын хувийн эрүүл мэндийн түүхийг нууцллах ёстой.

21. “Ажлын байрны мониторинг” гэж юуг хэлэх вэ?

Ажлын байрны мониторинг гэдэгт ажлын байрны үзлэг, үйлдвэрийн эрүүл ахуйн мониторинг, ажил гүйцэтгэх чадавхийн мониторинг, ажлын байрны орчин нөхцөл болон бусад ижил төстэй үйл ажиллагаанууд орох ба үүгээр хязгаарлагдахгүй.

22. “Босго” ба “өдөөгч” гэж юуг хэлэх вэ?

Компаниуд нь эгзэгийн хяналтын үл хүлцэх босго тодорхойлох үүрэгтэй. Энэхүү босгоос доогуур гүйцэтгэл нь судалгаанаас эхлэн тухайн ажлын үйл явцыг шууд зогсоох шийдвэр гаргах хүртэлх арга хэмжээг өдөөх ёстой.

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү: Олон улсын ашигт малтмал,

металлын зөвлөл: аюулгүй байдал ба эрүүл мэндийн эгзэгтэй цэгийн хяналтын удирдлага (ICMM. 2015. Health and Safety Critical Control Management). <http://www.icmm.com/website/publications/pdfs/health-and-safety/8570.pdf>

23. Уурхайн түвшний үүрэг амлалтыг нотлон харуулахын тулд компанийн түвшний баримт бичгийг ашиглаж болох уу?

Компанийн түвшинд дээд удирдлагын баримтжуулсан үүрэг амлалт (жишээ нь компанийн бодлого)-г уурхайн түвшинд хэрэгжүүлж, мөрдөж байгааг уурхайн түвшний өөрийн үнэлгээ эсвэл ТУУТ стандартын шалгалтаар нотолсоныг баримтаар хавсаргасан тохиолдолд нотлогоо гэж хүлээн зөвшөөрч болно. Компанийн баримт бичиг болон уурхайн түвшний дадал хоорондын холбоог харуулсан нотолгоо байх ёстой. Хэрэв ийм холбоо байгаа бол компанийн баримт бичгийг уурхайн түвшний үүрэг амлалтын нотолгоо хэмээн үзэж болно.

24. Аюулгүй байдал ба эрүүл мэндийн үүрэг амлалтууд нь ТУУТ стандартын аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтэцтэй нийцэж байгааг байгууллага хэрхэн тодорхойлох вэ?

ТУУТ стандартын аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтэц нь гишүүн компаниуд дагаж мөрдөхийг зөвшөөрсөн хэд хэдэн үүрэг амлалт тогтоосон. Компанийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн талаарх үүрэг амлалтын амин сүнс ба зорилго нь энэ бүтцэд нийцсэн байх ёстой. Компанийн үүрэг амлалтууд нь тухайн бүтцийг шууд эсвэл бүтцэд дурдсан бүх үүрэг амлалтыг эшлэх шаардлагагүй.

25. Ажилтнууд нь аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үүрэг амлалтаа хэрхэн нотлон харуулж болох вэ?

Ажилтнууд аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үүрэг амлалтаа нотлон харуулж буйг үнэлэх хэд хэдэн арга байдаг. Жишээ нь ажлын байрны шалгалт ба үзлэг, гол сэдвээр (ялгаварлал, дарамт гэх мэт) ажилтнуудын дунд хийсэн судалгаа эсвэл аюулгүй байдлын бодлого ба дүрмийн мөрдөлт (жишээ нь хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах, аюултай нөхцөл байдал эсвэл зан үйлийн талаарх мэдээлэх гэх мэт) зэрэг аргууд байж болно.

26. Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөрт юу багтаж болох вэ?

Ихэвчлэн үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөрт доорх зүйлс орно:

- Ажлын байран дээрх үйл ажиллагаанаас үүдэх болзошгүй өртөлтийг (хортой бодис худалдан авах, ашиглах) таамаглах.
- Чанарын аргаар өртөлтийг тодорхойлох (жишээ нь ажлын байраар явж судалгаа хийх).
- Бохирдуулагч бодисоос дээж авах авах ба мониторинг хийх хийх замаар өртөлтийг үнэлэх (хэрэглэх шалгуур ашиглан тоон болон чанарын).
- Зөвшөөрөгдөх түвшинд хүртэл өртөлтийн хяналт хийх (хяналтын шатлал ашиглан).

- Хяналтын үр нөлөө – өртөлтийг арилгах эсвэл бууруулах зорилгоо биелүүлж байна уу.

27. Эгзэгийн хяналтын зорилтууд ба гүйцэтгэлийн шаардлагыг уурхай хэрхэн тогтоож болох вэ?

Эгзэгийн хяналтын зорилтууд, гүйцэтгэлийн шаардлагуудыг тодорхойлох болон гүйцэтгэлийг хэрхэн шалгах нь эгзэгийн хяналтын менежментийн чухал алхам юм. Эгзэгийн хяналтын үүрэг, хүлээлт ба гарах үр дүнг бүрэн ойлгохын тулд компани эгзэгийн хяналтын зорилт тодорхойлохоос эхэлж болно. Хяналт тавигдах стандарт гүйцэтгэлийн шаардлагууд нь үйлдэл ба тоон утгаас бүрдэнэ. Хяналтын гүйцэтгэлийн шаардлагууд нь компанийн баримт бичигт аль хэдийн туссан байж болно. Үүнийг холбогдох үйл явц, заавар, ашиглалтын гарын авлага болон бусад баримт бичигт дүн шинжилгээ хийх замаар тодорхойлж болно. Салбарын стандартууд нь гүйцэтгэлийн шаардлагыг тодорхойлоход тус болж болно. Гэвч салбарын стандартууд нь тодорхой бус эсвэл хяналтын агуулгатай эсвэл шууд хамааралгүй байж болох тул болгоомжлох нь зүйтэй. Гүйцэтгэлийн шаардлага нь тодорхой, хэмжигдэхүйц, тохиромжтой, бодит байвал зохино. Ажиллагааг зогсоох, эсвэл өөрчлөх, эсвэл эгзэгийн хяналт сайжруулах дохио өгөхийн тулд яаралтай арга хэмжээ эхлүүлэхэд хүргэх гүйцэтгэлийн түвшинг тодорхойлох нь бас чухал юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг Олон улсын ашигт малтмал, металлын зөвлөл: Эгзэгтэй хяналтын менежментийг хэрэгжүүлэх заавар дээр үзнэ үү (ICMM. 2015. Critical Control Management Implementation Guide). <http://www.icmm.com/website/publications/pdfs/health-and-safety/8570.pdf>

28. Уул уурхайн салбарт төлөөлөл багатай ямар бүлгүүд байдаг вэ?

Үндэсний болон орон нутгийн өөр өөр төлөв байдалд өөр өөр бүлгүүд төлөөлөл багатай байж уул уурхайн салбарт янз бүрийн түвшний эмзэг байдал ба гадуурхалт мэдрэх магадлалтай. Үндэсний болон төлөв байдалд хамаарах төлөөлөл багатай бүлгүүдийг тодорхойлохын тулд ажилчид болон холбогдох сонирхолын бүлгүүдтэй хамтран ажиллах болон холбогдох орон нутгийн хууль тогтоомж, ажиллах хүч, хүн ам зүйн өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд нь компаниудыг урамшуулдаг.

Жишээ нь НҮБ-аас “ялгаварлан гадуурхах, тэр дундаа уугуул иргэд, цагаачид, цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, арьс өнгө, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаагаар ялгаварлан гадуурхах тодорхой хэлбэрүүдтэй тэмцэх олон улсын арга хэрэгсэлүүд”-г эш татдаг.

Канадад Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын тухай хуульд хөдөлмөр эрхлэлтийн дөрвөн бүлэг тодорхойлсон. Үүнд: эмэгтэйчүүд, уугуул иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цөөнхийн бүлгийн гишүүд. АНУ-ын хувьд Иргэний эрхийн тухай хуулийн 7 дугаар бүлэг нь хөдөлмөр эрхлэлтэд арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, үндэсний гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахыг хориглодог.

Үндэстний бус жишээ гэвэл Канадын Онтарио мужийн Хүний эрхийн тухай Кодекс "Үндэслэл гэж нэрлэгддэг хувь хүний 17 шинждээр суурилсан ялгаварлан гадуурхалт нь энэхүү Кодексийн дагуу хууль бус хэмээн тооцогдоно. Эдгээр үндэслэл нь иргэний харьяалал, арьс өнгө, гарал үүсэл, үндэс угсаа, өнгө, удам угсаа, хөгжлийн бэрхшээл, нас, итгэл үнэмшил, хүйс/жирэмслэлт, гэр бүлийн байдал, гэрлэлтийн байдал, бэлгийн чиг хандлага, жендер, жендерийн илэрхийлэл, төрийн тусламж хүртэх байдал (орон сууцны дэмжлэг) болон хөдөлмөр эрхлэлтийн зөрчлийн түүх (хөдөлмөр эрхлэлт дээр) зэрэг байна" гэж заасан.

Компаниуд нь олон улсын болон орон нутгийн эрх зүйн баримт бичгийн тодорхойлолтоор хязгаарлагдахгүйгээр үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрт бага төлөөлөлтэй бүлгүүдийг тодорхойлох үед эдгээрийг ажилчид болон сонирхолын бүлгүүдтэй ярилцах эхлэл болгон ашиглаж болно. Зарим компаниуд нь бага төлөөлөлтэй тодорхой бүлэгт төвлөрөн анхааралаа хандуулж эхэлж болох ч эцсийн зорилго нь хүн бүрт хүнд тэгш, олон янз, оролцоотой ажлын байрыг бий болгох явдал байх ёстой.

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү: НҮБ Тэгш байдал болон үл алагчлал (United Nations. n.d. Equality and Non-Discrimination). <https://www.un.org/ruleoflaw/thematic-areas/human-rights/equality-and-non-discrimination/> (Энэхүү вэбсайт нь тодорхой хэлбэрийн алагчлалтай тэмцэх талаарх олон улсын арга хэрэгслийн холбоосыг багтаасан)

Онтарио мужийн Хүний эрхийн комисс (Ontario Human Rights Commission). 2013. Хүний эрхийн хуульд заасан таны эрх, үүргийн хөтөч (Guide to your rights and responsibilities under the Human Rights Code). <https://www.ohrc.on.ca/en/guide-your-rights-and-responsibilities-under-human-rights-code-0> (Тус баримт бичигт Онтарио мужийн Хүний эрхийн хууль, бодит амьдралын жишээг тусган харуулсан.)

Канад улсын Засгийн газар (Government of Canada). 1995. Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын тухай хууль (Employment Equity Act (S.C. 1995, c. 44)). <https://laws-lois.justice.gc.ca/eng/acts/E-5.401/index.html>

АНУ-ын Тэгш хөдөлмөр эрхлэлтийн боломжийн комисс (U.S. Equal Employment Opportunity Commission). 2000. 1964 оны Иргэний эрхийн тухай хуулийн VII зүйл (Title VII of the Civil Rights Act of 1964). <https://www.eeoc.gov/statutes/title-vii-civil-rights-act-1964>

29. Компаниуд нь ажилтнуудын дунд тааламжгүй тохиолдолыг албан бусаар шийдэхэд хэрхэн дэмжлэг үзүүлж болох вэ?

Төрөл бүрийн сургалт ба нөөц нь ажилтнуудад ажлын байран дээрх гэмтэй, аюултай эсвэл хүндлэлгүй зан үйлийн тааламжгүй тохиолдолыг шийдвэрлэх чадвар ба ойлголт бий болгоход туслах боломжтой. Уурхай нь ийм тааламжгүй тохиолдолыг шийдвэрлэхийн тулд ойлголцдог, хэлэлцүүлэг хийдэг, зөрчил шийдвэрлэхийг дэмждэг ажлын байрны соёлыг хөгжүүлэх зорилготой байхаас гадна аливаа тааламжгүй тохиолдолын хувьд үр нөлөөтэй шийдвэр эрэлхийлэхийг эрчимжүүлэхэд шаардагдах албан ёсоор тайлагнах ба хариу өгөх механизм санал болгодог байвал

зохино. Жишээлбэл, хөндлөнгийн хүмүүсийн зохих сургалт, дэмжлэгээр дамжуулан ажилчид болон менежерүүдэд бичил түрэмгийлэл, эелдэг бус байдал зэрэг зан үйлийг илүү ноцтой зан үйл эсвэл осолд хүргэхээс өмнө шийдвэрлэх эрх мэдэл олгож болно.

30. Ажлын байран дээрх аюултай, гэмтэй, хүндлэлгүй зан үйлийн хариу өгөх механизм бүрдүүлэхэд уурхай нь юуг анхаарч үзвэл зохих вэ?

Хариу өгөх механизмыг бий болгох ба дүн шинжилгээ хийхдээ юуны өмнө ажилтнууд нь тэдний санаа зовж буй асуудлыг уурхайн зүгээс нухацтай авч үзэж, зохих арга хэмжээг хэрэгжүүлнэ гэдэгт итгэдэг байх нь чухал. Уурхай нь өөртөө байгаа хариу өгөх механизмыг сайжруулах эсвэл протоколын шаардлагыг биелүүлэхийн тулд шинэ механизм бий болгож болно. Хариу өгөх механизмыг боловсруулах эсвэл дүн шинжилгээ хийхдээ уурхай нь дараах элементүүдийг авч үзнэ:

- Ажилчид механизмын тухай болон хэрхэн ажилладаг, хэзээ хэрхэн ашиглах талаар ажилтнууд мэдлэг ойлголтой байх.
- Хариу өгөх үйл явц нь шуурхай, асуудал шийдэгдэх хүртэл нөлөөнд өртсөн ажилтан эсвэл бүлэгт байнга шинэчилсэн мэдээлэл хүргэдэг байх.
- Хариу өгөх үйл явц нь хохирол эсвэл хэлмэгдэлээс зайлсхийхийн тулд өөрөөр хүсэлт гаргаагүй бол нөлөөнд өртсөн хувь хүн эсвэл бүлгийн нууцыг хамгаалах зорилготой байх.
- Хариу өгөх механизм нь нөлөөнд өртсөн хувь хүн эсвэл бүлгүүдэд дэмжлэг үзүүлэхийн тулд гэмтэл-мэдээллийн үйл явцтай, эрт оролцох стратегитай байх бөгөөд эдгээр дэмжлэгийг судалгааны явцад болон дараа нь ашиглах боломжтой хэвээр байх.
- Судалгааны үйл явц нь нууц ба шударга явагддаг бөгөөд судалгааны арга барилын талаар нөлөөнд өртсөн хувь хүн эсвэл бүлгийн санал хүсэлтийг харгалзан холбогдох бүх хувь хүн эсвэл бүлэгт тохирсон халамжлах үүргийг авч үзэх.
- Судалгааны үйл явц нь юу тохиолдсон, түүнчлэн түүний үндсэн болон хавсарсан шалтгааныг тодорхойлохыг эрмэлзэх.
- Механизмд мэдээлсэн асуудлууд, хариу арга хэмжээ, үр дүн ба хамаарах хугацаа зэргийг нууцын зэрэгтэй бүртгэж хадгалах.
- Хариу өгөх үйл явцыг үнэлэх, сургамжуудад дүн шинжилгээ хийх, шаардлагатай бол тохируулга хийх үйл явц бий болгох.

Энэ нь бүх үр дүнд бүх талууд бүрэн сэтгэл хангалуун байна гэсэн үг биш юм. Хэдийгээр хариу өгөх механизмын үр дүн нь нөлөөнд өртсөн хувь хүний хүссэнээр биш байсан ч, мэдээлэгдсэн тааламжгүй тохиолдолын нөлөөнд өртсөн хүмүүсийг дэмжих нөөцтэй байвал зохино. Тухайн хүний туршлага нь судалгааны явцад гарсан үр дүнгээс ялгаатай байсан ч хохирол амссан байж болзошгүй гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал юм.

31. Дарамт, гадуурхалт, хүчирхийлэл зэрэг асуудлыг шийдэхэд ашиглаж болох гаднах механизмуудын ямар жишээ байж болох вэ?

Энэхүү протокол нь ажлын байран дахь аюултай, гэмтэй, үл хүндэтгэсэн зан үйлийн тааламжгүй тохиолдлуудад хариу арга хэмжээ авахын тулд гэмтэл мэдээллийн үйл явцтай байхыг шаардахын зэрэгцээ дарамт, гадуурхалт болон хүчирхийлэл зэрэг асуудлыг шийдүүлж болох эрх зүйн гадаад механизм ажилтануудын хувьд байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал. Жишээ нь Канад улсын хувьд Канадын Хүний эрхийн шүүх, муж улсын хүний эрхийн газар ба байгууллагууд, эрүүгийн хууль, хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль, лиценз олгох мэргэжлийн байгууллагууд, эвлэрүүлэн зуучлах ба маргаан шийдвэрлэх бусад үйлчилгээ, цагдаагийн үйлчилгээ, хамтын гэрээ мэт зүйлс боломжтой байдаг.

32. Сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэл, хүртээмжийг чухалчлах ажлын байрны дизайн боловсруулахад ямар зүйлсийг анхаарч үзэх вэ?

Дэд бүтэц ба тоног төхөөрөмж нь ажлын байрны аюулгүй байдал ба хүртээмжид нөлөөлдөг олон арга зам бий. Анхаарч үзэх зарим зүйлсэд жишээ нь эмэгтэйчүүдэд зориулсан угаалгын өрөө; жендер үл хамаарах дэд бүтэц; янз бүрийн жендер, биеийн төрөл ба хэрэгцээнд тохирсон хувийн хамгаалах хэрэгсэл; хувийн орон зай (хүүхэд хөхүүлэх эсвэл мөргөл хийх) зэрэг нь багтана. Эдгээр хэрэгцээ нь ажлын байр бүрт өвөрмөц байх тул ажилтнууд ба сонирхолын бүлгийн оролцоо болон дотоод үнэлгээ эсвэл аудитын тусламжаар тодорхойлно. Хүртээмжтэй, хүндлэлтэй ажлын байрыг төлөвшүүлэх хүчин чармайлтад нь саад учруулж болзошгүй биеийн болон нийгэм сэтгэл санааны аюулыг тодорхойлох ба үнэлэхэд ажилчид болон сонирхолын бүлгүүдийг компаниуд татан оролцуулвал зохино. Жишээлбэл, уурхай нь янз бүрийн биеийн төрөл ба хэрэгцээнд зориулагдсан хувийн хамгаалах хэрэгсэл ба хүйсийн онцлогт тохиромжтой уурхай зэрэг аюулгүй, тэгш, хүртээмжтэй байдалд учруулж болох бодит саадыг тодорхойлох ба үнэлэх боломжтой. Хүчирхийлэл ба дарамт зэрэг хүмүүс хоорондын зан үйл нь ажилчдад нөлөөлж болно. Илрүүлсэн аюул ба эрсдэлийг арилгах арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлвэл зохино.

33. Бэлгийн дарамттай тэмцэхэд компаниуд ашиглаж болох ямар эх сурвалжууд байдаг вэ?

Австралийн эрдэс баялгийн зөвлөл нь бэлгийн дарамтыг арилгах үүрэг амлалтаа биелүүлэхэд зориулан салбарын кодекс боловсруулсан. Энэхүү кодекс нь шударга, хүндлэлтэй, нээлттэй мэдээлэл харилцаанд анхаарлаа хандуулдаг хүндлэлийн соёлыг төлөвшүүлэх хүлээлтийг компаниудад зориулж тодорхойлсон. Уг баримт бичигт бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үндсэн арга хэмжээг тусгасан.

Дэлгэрэнгүй мэдээллийг доор үзнэ үү: Австралийн эрдэс баялгийн зөвлөл (Minerals Council of Australia). 2021. Бэлгийн хүчирхийлэлтэй тэмцэх салбарын журам (Industry Code on Eliminating Sexual Harassment) https://www.minerals.org.au/sites/default/files/Sexual%20Harassment_Industry%20Code%20of%20Conduct_March%202021.pdf

Уул уурхайн салбарын хүний нөөцийн зөвлөл (Mining Industry Human Resources Council). 2022. Аюулгүй ажлын байрыг бүгдэд- тайлан: Канадын уул уурхайн салбар дахь бэлгийн хүчирхийллийн асуудлыг шийдэх нь (Safe Workplaces for All Report: Addressing Sexual Harassment in Canadian Mining). <https://mihr.ca/wp-content/uploads/2022/11/Safe-Workplaces-For-All-Report-EN.pdf>

Доорхыг мөн үзнэ үү: Me Too Уул уурхайн холбоо (Me Too Mining Association). 2019. DIGGER хөтөлбөрийн сургалт (DIGGER Program Training). <https://www.metoomining.com/training.html>

34. Ажилчдын сэтгэцийн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрт ямар зүйлс багтаж болох вэ?

Ажилчдын сэтгэл санааны эрүүл мэндийн хөтөлбөрт зориулсан олон тооны эх сурвалжууд байдаг ба эдгээр нь хөтөлбөрт зориулсан зааварчилгаа ба зөвлөмжүүдийг тусгасан байдаг.

Жишээ нь: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (World Health Organization). 2022. ДЭМБ-ын ажлын байран дахь сэтгэл санааны эрүүл мэндийн гарын авлага (WHO Guidelines on Mental Health at Work.) <https://www.who.int/publications/i/item/9789240053052>

Канад улсын сэтгэл санааны эрүүл мэндийн комисс (Mental Health Commission of Canada). 2023. 13 хүчин зүйлс: Ажлын байран дээрх сэтгэл санааны эрүүл мэнд (13 Factors: Addressing Mental Health in the Workplace). <https://mentalhealthcommission.ca/13-factors-addressing-mental-health-in-the-workplace/>

CAMH. 2020. Ажлын байрны сэтгэл санааны эрүүл мэнд: Тойм болон зөвлөмжүүд (Workplace Mental Health: A Review and Recommendations). <https://www.camh.ca/-/media/files/workplace-mental-health/workplacementalhealth-a-review-and-recommendations-pdf.pdf>

Канадын ажлын байрны аюулгүй байдал ба эрүүл мэндийн төв (Canadian Centre for Occupational Health and Safety). 2022. Ажлын байран дээрх эрүүл мэнд, тавлаг байдал (Workplace Health and Well-being). https://www.ccohs.ca/oshanswers/psychosocial/wh/mentalhealth_work.html

Ажлын байрны сэтгэл санааны эрүүл мэндийн стратегиуд (Workplace Strategies for Mental Health). 2023. сэтгэл санааны эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүд (Mental Health Policies and Programs). <https://www.workplacestrategiesformentalhealth.com/resources/mental-health-policies-and-programs>

35. Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийг олон нийтийн дунд төлөвшүүлэхийн тулд холбогдох сонирхолын бүлгүүдтэй уурхай хэрхэн хамтран ажиллаж болох вэ?

Ажилчид болон орон нутгийн иргэдтэй хамтран ажилласнаар уурхай нь олон нийтийн орчинд сэтгэл санааны хувьд аюулгүй, эрүүл, хүндлэлтэй зан үйлийг төлөвшүүлэх хэд хэдэн арга замыг тодорхойлж болно.

Жишээлбэл, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг сургалтын хөтөлбөрүүдийг олон нийтийн байгууллагуудтай хуваалцах эсвэл хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд зориулсан бүс нутгийн хэмжээнд тусламжийн утас ажиллуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг байж болно.

36. Компани нь сургагч нарынхаа чадамж ба үр нөлөөг үнэлдэг гэдгээ хэрхэн нотлон харуулж болох вэ?

Тухайн этгээд нь мэргэшсэн эсэхийг тодорхойлоход дараах зүйлсийг анхаарах ба үүгээр хязгаарлагдахгүй:

- Сургалтууд хийж байсан туршлага.
- Ажил ба үйл ажиллагааны туршлага.
- Сургагчийн чадамжийн шалгалт эсвэл олгосон зөвшөөрөл/уурхайгаас/.
- Аюулгүй байдал ба эрүүл мэндийн тодорхой сэдвүүдийн мэдлэг ба сургалт, албан ёсны боловсрол, сургалт, гуравдагч талын олгосон гэрчилгээ.
- Сургалтын хөтөлбөрийн сэдвүүтэй холбоотой ажлын түүх.

37. Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлт зан үйлийг салбарын нийтлэг гүйцэтгэлтэй хэрхэн харьцуулан үнэлэх вэ?

Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн тааламжгүй тохиолдолын талаарх салбарын түвшний мэдээ тайлан хангалттай их, дүн шинжилгээ хийх боломж сайтай хэдий ч биеийн аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйлийн талаарх зарим мэдээлэл хүртээмж муутай тул харьцуулах жишиг хэмжүүрийн хувьд зарим хязгаарлалтууд байж болно. Компаниуд нь эдгээр асуудалд мониторинг хийж, тайлагнаж эхлэснээр өгөгдөл мэдээллийн хүртээмж сайжирч болно.

38. Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийн гүйцэтгэлийн талаар уурхай ямар мэдээлэл тайлагнаж болох вэ?

Уурхай нь өөрийн ажилтнууд болон холбогдох сонирхолын бүлэгүүдтэй хамтран сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийн гүйцэтгэлийг тайлагнахад хамгийн их хамааралтай мэдээллийн төрлийг тодорхойлж болно. Жишээ нь Даян дэлхийн тайлагналын санаачилга (Global Reporting Initiative) 403: Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл мэнд (Occupational Health and Safety) хэсэгт ажлын байран дээрх хүчирхийлэл, бэлгийн дарамт зэрэг асуудлыг ажилтай холбоотой тааламжгүй тохиолдлыг тодорхойлоход, аман хэлбэрийн хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлт зэрэг нийгэм-сэтгэл санааны аюулыг ажилтай холбоотой сэтгэл санааны аюул тодорхойлоход багтаадаг. Бусад олон тайлан дундаас Даян дэлхийн тайлагналын санаачилга 403 нь компаниудаас доорх зүйлсийг тайлагнахыг шаарддаг:

- Ажилтай холбоотой тааламжгүй тохиолдол судлахад хэрэглэдэг үйл явц.
- Ажилтай холбоотой аюул илрүүлэх ба эрсдэл үнэлэхэд хэрэглэдэг үйл явц.
- Ажилтай холбоотой аюул болон аюултай нөхцөл байдлыг ажилчидаас мэдээлэх үйл явц.

- Ажилтай холбоотой тодорхой аюулын талаар ажилчдад хийх сургалт.
- Ажилтай холбоотой их үр дагавартай гэмтэлд хүргэх эрсдэлтэй аюул.
- Ажилтай холбоотой бусад аюулыг арилгахын тулд авч хэрэгжүүлэх эсвэл хэрэгжүүлж буй арга хэмжээ.
- Ажилтай холбоотой эрүүл мэнд хохироох эрсдэлтэй аюул.

Дэлгэрэнгүй мэдээллийн доор үзнэ үү: Даян дэлхийн тайлагналын санаачилга (GRI). 2018. Ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа (GRI 403: Occupational Health and Safety). <https://www.globalreporting.org/standards/media/1910/gri-403-occupational-health-and-safety-2018.pdf>

39. Ямар түвшинд жишиж үзэх нь хангалттай гэж тооцогдох вэ?

Үүнийг хийхэд тодорхой хязгаарлалтууд байдгийг харгалзан, үзүүлэлт 6: Биеийн аюулгүй байдал ба, эрүүл мэндийн гүйцэтгэл (АА түвшин)-н хувьд уурхай эсвэл компани нь өөрийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийг бусдын гүйцэтгэлтэй тогтмол (жишээ нь сүүлийн гурван жилийн дотор) жишиж байх нь зохистой. Уурхай эсвэл компани эдгээр харьцуулсан өгөгдөл мэдээлэл олж авахын тулд хэд хэдэн арга эсвэл эх сурвалжуудыг ашиглаж болох ба үүнд, тухайлбал нийтлэгдсэн салбарын нийтлэгдсэн өгөгдөл мэдээлэл (боломжтой бол) ашиглах, нийтэд нээлттэй өгөгдөл мэдээллийг нэгтгэх, харьцуулж жиших судалгааг эхлүүлэх зэрэг нь багтаж болно.

40. Хүний амь эрсдэх нь 6 дугаар үзүүлэлтийн хувьд уурхай А түвшинг хангахад саад болох уу?

Тайлангийн жилд үйлдвэрлэлийн ослоор хүний амь нас хохирсон уурхай нь 6 дугаар (гүйцэтгэл) үзүүлэлтийн хувьд дээр А эсвэл үүнээс дээш түвшнийг хангах боломжгүй. Удирдлагын хяналтад байгаа үйл ажиллагаанаас үүдэн ажилтай холбоотой тааламжгүй тохиолдолын улмаас ажилтан, гэрээлэгч ба зочин нас барсныг үйлдвэрлэлийн осол гэж тодорхойлдог.

АУДИТ

41. “Аудит” гэж юуг хэлэх вэ?

Аудит гэж тодорхой, тохиролцсон, урьдчлан тогтоосон шалгуурт тохирч байгаад хийсэн албан ёсны, эмх цэгцтэй, баримтжуулсан шалгалтыг хэлнэ.

Аудит нь холбогдох нотолгоог эмх цэгцтэйгээр цуглуулж, баримтжуулсаны үндсэн дээр тогтоосон шалгуурт тохирч буй хэр хэмжээг үнэлэх ба тайлагнадаг. Аудит нь тодорхой хэмжээний шүүлт агуулдаг боловч дутагдалын үндсэн шалтгааныг тогтооход зориулагдаагүй. Аудитыг дотоодын эсвэл гадны мэргэжилтэн хийж болно.

Дотоод аудитыг зохих мэдлэг ба чадамжтай компанийн ажилтнууд хийнэ. Эдгээр ажилтнууд нь аудит хийгдэж буй уурхайн удирдлагын хувьд хараат бус, шударга ба бодит байдлыг хангана. Жишээ нь тэд өөр уурхайд эсвэл компанийн түвшинд ажилладаг хүмүүс байж болно.

Гадаад аудитыг аудит хийлгэж буй компанийн гаднах аудиторуд хийнэ. Үр дүн ба дүгнэлтийг зөвхөн нотолгоонд үндэслэсэн явдлыг хангахын тулд эдгээр аудиторуд аудитын үйл явцын туршид бодиттой байх байр суурийг баримтална.

Үзүүлэлт 5: Мониторинг болон тайлагнал- Аудитын үйл ажиллагаа нь аюулгүй байдал ба эрүүл мэндийн талаарх өгөгдөл мэдээлэл цуглуулах, эмхэтгэх, тайлагнах үйл явцыг үнэлэх, тодорхойлсон үйл явцууд бий болсон талаарх мэдээллийг баталгаажуулах, тэдгээр нь тууштай хэрэгжиж байгаа эсэхийг шалгах зорилготой.

Үзүүлэлт 6: Гүйцэтгэл (AAA түвшин)- Гадаад аудитын үйл ажиллагаа нь цуглуулсан суурь өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар аюулгүй байдал ба эрүүл мэндийн талаарх цуглуулсан өгөгдөл мэдээллийн үнэн зөв ба найдвартай байдлыг шалгах, эдгээр өгөгдөл мэдээллийг үнэн зөв шүүж өгөгдөл мэдээллийн санд оруулсаныг шалгах, нэгтгэсэн өгөгдөл мэдээлэлд дүн шинжилгээ хийх зорилготой.

42. Компани эсвэл уурхай нь АА түвшний дотоод аудитыг хийлгэж дуусалгүйгээр гадаад аудитыг амжилттай хийлгэснээр AAA түвшнийг ханган биелүүлж болох уу?

Болно, учир нь ТУУТ стандартын гүйцэтгэлийн үзүүлэлтийн үнэлгээ нь компани эсвэл уурхайн тухайн агшины төлөв байдлын зураглалыг тодорхой үзүүлэлт тус бүрээр харуулдаг. АА эсвэл ААА түвшнийг хангасан гэж үзэх нь аудит нь дотоод эсвэл гадаад гэдгээс хамаардаг. Компани эсвэл уурхай нь гадаад аудит хийлгэж ААА түвшний үнэлгээ авахын өмнө дотоод аудит (АА түвшний үнэлгээ авах боломжтой) хийх шаардлагагүй.

43. Дотоод болон гадаад аудит ямар хугацаанд хүчинтэй вэ?

Сүүлийн 3 жилийн хугацаанд хийгдсэн дотоод эсвэл гадаад аудит нь энэхүү протоколын олон үзүүлэлтийн хувьд АА эсвэл ААА түвшинд заасан дотоод эсвэл гадаад аудит хийлгэх шаардлагыг хангана.

ХАВСРАЛТ 2: ТУУТ СТАНДАРТЫН ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГАХ ХУУДАС

Аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байр

Уурхайн нэр:		Компанийн нэр:	
Үнэлгээ хийсэн:		Хүргүүлсэн огноо:	

Дэмжих баримт бичиг / Нотолгоо:	
Баримт бичгийн нэр	Байршил

Ярилцлагад хамрагдсан хүмүүс:			
Нэр	Албан тушаал	Нэр	Албан тушаал

АСУУЛТ		Т	Ү	NA	ТАЙЛБАР болон НОТОЛГОО
ҮЗҮҮЛЭЛТ 1: Үүрэг амлалт ба эгэх харуцлага					
Үзүүлэлт 1 Түвшин В	1.	Аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үүрэг амлалт нь илт харагдаж байна уу?			
	2.	Нэг эсвэл түүнээс дээш удирдлагын төлөөлөл аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх эгэх хариуцлага хүлээж байна уу?			
	3.	Уурхай нь А түвшний бүх шаардлагыг хангахын тулд арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан уу?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь С түвшинг хангасан хэмээн үнэлнэ				
Үзүүлэлт 1 Түвшин А	1.	ТУУТС-н аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтцэд нийцсэн аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх дээд удирдлагын үүрэг амлалт харагдаж байна уу?			
	2.	Компанийн аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх үүрэг амлалтын талаар уурхай дээр ажиллаж буй ажилтнууд, гэрээлэгчид болон ханган нийлүүлэгч нарт мэдлэг ойлголт өгөх үйл явц бий болсон уу?			
	3.	Удирдлага болон ажилтнуудын үүрэг хариуцлага ба эгэх хариуцлагыг бүх шатанд ойлгосон байна уу?			
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь В түвшинг хангасан хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 1 Түвшин АА	1.	Дараах зүйлсийг тодорхойлох дотоод аудит хийгдсэн уу?				
	a.	Үүрэг амлалт нь ТУУТС-н аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтцийн зорилготой хэр хэмжээнд нийцэж байгаа эсэх				
	b.	Үүрэг хариуцлага ба эгэх хариуцлагыг удирдлага болон ажилтнууд ойлгосон эсэх?				
	c.	Үүрэг амлалтыг уурхай дээрх ажилтнууд, гэрээлэгчид болон ханган нийлүүлэгчдэд мэдээлж харилцсан эсэх болон эдгээр талуудад мэдлэг ойлголт өгөх үйл явц тогтсон эсэх?				
	2.	Уурхай дээрх ажилтнууд нь аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны талаарх өөрсдийн үүрэг амлалтыг илтгэн харуулж байна уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь А түвшинг хангасан гэж үнэлнэ.					
Үзүүлэлт 1 Түвшин ААА	1.	Дараах зүйлсийг тодорхойлох гадаад аудит хийгдсэн байна уу?				
	a.	Үүрэг амлалт нь ТУУТС-н аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны бүтцийн зорилготой хэр хэмжээнд нийцэж байгаа?				
	b.	Үүрэг хариуцлага ба эгэх хариуцлагыг удирдлага болон ажилтнууд ойлгосон эсэх?				
	c.	Үүрэг амлалтыг уурхай дээрх ажилтнууд, гэрээлэгч болон ханган нийлүүлэгч нарт мэдээлж харьцсан эсэх?				
	d.	Уурхай дээрх ажилтнууд, гэрээлэгч болон ханган нийлүүлэгч нарт үүрэг амлалтын талаар мэдээлж харилцах үйл явцын үр нөлөөтөй байдал?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэл нь ААА хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь АА түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 1 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ						Түвшин: _____

АСУУЛТ		T	Y	NA	Талбайр болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 2: Аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоо					
Үзүүлэлт 2 Түвшин В	1.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн зарим тогтолцоо бий болсон, үүнд таарамжгүй тохиолдлыг мэдээлэх ба судлах тодорхой үйл явц багтсан уу?			
	2.	Эрсдэл хяналтын арга хэрэгслийг тодорхойлсон ба хэрэглэхэд бэлэн болсон уу?			
	3.	Уурхай дээрх хамгийн түгээмэл ажлыг тодорхойлсон уу?			
	4.	Уурхайн дээрх хамгийн түгээмэл ажлын стандарт ажиллагааны заавар болон аюулгүй ажиллах дадал бий болсон уу?			
	5.	Уурхай нь А түвшний бүх шаардлагыг хангахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулсан уу?			
Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь С түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					

Үзүүлэлт 2 Түвшин А	1.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн баримтжуулсан тогтолцоо бүрдэж, хэрэгжиж, хэвийн ажиллаж байна уу?. Үүнд дараах зүйлсийг тусгасан уу?				
	a.	Зорилго ба зорилтууд, эдгээрийн биелэлтийг хангах төлөвлөгөө				
	b.	Аюул илрүүлэх, эрсдэл үнэлэх (АИЭҮ) ба хяналтын үйл явц				
	c.	Үр дагавар ихтэй аюул илрүүлэх ба холбогдох эгзэгийн хяналт				
	d.	Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөр				
	e.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага ба эгэх хариуцлага				
	f.	Ажлын байрны үзлэг шалгалт				
	g.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн бүртгэл хөтлөлт				
	2.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн ажиллуулах болон сайжруулах, хяналтын үр нөлөөг баталгаажуулахад зориулан нөөц хуваарилсан.				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь В түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					

Үзүүлэлт 2 Түвшин АА	1.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны төлөвлөлт болон хэрэгжилт нь А түвшинд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхэд дотоод аудит хийгдсэн үү?				
	2.	Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн эрсдэл ба хяналтад мэргэшсэн эрүүл ахуйч дүн шинжилгээ хийдэг үү?				
	3.	Уурхай нь эгзэгийн хяналт бий болж, ажиллаж байгааг шалгаж нотолсон, түүнчлэн, эгзэгийн, зайлсхийх ба энгийн хяналтын ялгааг тодорхойлж гаргасан уу?				
	4.	Уурхай нь нийгэм -сэтгэл санааны аюул ба гэмт зан үйлийг тодорхойлж, боломжит эрсдэлийг үнэлж, удирдаж, мониторинг хийдэг үү?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь А түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
Үзүүлэлт 2 Түвшин ААА	1.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн менежментийн тогтолцооны төлөвлөлт болон хэрэгжилт нь А түвшинд тавигдах шаардлагыг хангаж буй эсэхэд гадаад аудит хийгдсэн үү?				
	2.	Үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хөтөлбөр нь мэргэшсэн эрүүл ахуйчийн удирдлага дор хэрэгждэг үү?				
	3.	Уурхайн онцлогтой болон аюултай ажлыг тодорхойлж, эдгээрт зориулсан эгзэгийн хяналтыг хяналт тодорхойлох тогтсон арга зүйг ашиглан бий болгосон уу (жишээ нь эрвээхэй зангианы шинжилгээ)?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэл нь ААА хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь АА түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 2 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ						Түвшин: _____

АСУУЛТ		Т	Ү	NA	Талбайр болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 3: Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйл					
Үзүүлэлт 3 Түвшин В	1.	Уурхай нь А түвшний бүх шаардлагыг хангахын тулд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулсан уу?			
	2.	Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй холбоотой тааламжгүй тохиолдлыг ажилтан нар нь мэдээлдэг ажилчдад зориулсан механизмтай юу?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь С түвшинг хангасан хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 3 Т үвшин А	1.	Сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйл төлөвшүүлэхийг дэмжиж, нэгтгэх зорилготой бодлого ба үйл явцад дүн шинжилгээ хийдэг үү?			
	2.	Уурхай нь эрүүл мэнд ба тааламжтай байдлыг төлөвшүүлэх, үүнд сэтгэл санааны эрүүл мэнд болон эрүүл амьдралын хэв маяг багтсан, хөтөлбөртэй юу?			

Үзүүлэлт 3 Түвшин А	3.	Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй зан үйлийг төлөвшүүлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа сэтгэл санааны эрүүл мэнд ба аюулгүй байдлын бодлого ба үйл явцыг ажилтнуудад мэдээлж харилцдаг үү?				
	4.	Ажлын байран дээрх сэтгэл санааны хувьд аюултай, гэмтэй эсвэл хүндлэлгүй зан үйлтэй холбоотой тааламжгүй тохиолдлыг мэдээлэх ба хариу арга хэмжээ авахад зориулсан гэмтэл-мэдээлэлд суурилсан үйл явц бүрдсэн үү?. Үүнд дараах зүйлс багтсан уу?:				
	а.	Ажлын байран дахь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлтэй холбоотой байнгын сайжруулалт хийх ба суралцах соёлыг төлөвшүүлэх зорилгоор хамт олны дунд тааламжгүй тохиолдлыг албан бусаар шийдэхэд дэмжлэг үзүүлэх сургалт ба нөөц				
	б.	Тааламжгүй тохиолдлыг албан бусаар шийдэх үйл явцаас гадуур судалж шинжлэх, эсвэл шийдвэрлэхэд дэмжлэг шаардагдах асуудал, гомдол ба саналыг хүлээн авч шийдвэрлэхэд зориулсан мэдээлэл тайлагналын шуурхай, нууцлалтай, шударга механизм?				
		Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь В түвшинг хангасан хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 3 Түвшин АА	1.	Уурхай нь А түвшний гэмтэлийн талаар мэдээлэл хүлээн авах ба шийдвэрлэхэд зориулсан гэмтэл- мэдээлийн үйл явцад дүн шинжилгээ хийхэд дотоод болон гадаад сонирхолын бүлгүүдтэй хамтран ажилладаг уу?				
	2.	Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал ба хүндлэлийг төлөвшүүлэх өөрийн бодлого ба үйл явцын талаар илүү өргөн хүрээнд буюу ханган нийлүүлэгч нарын сүлжээнд мэдээлж харилцдаг уу?				
	3.	Уурхай нь сэтгэл санааны аюулгүй, хүндэтгэлтэй зан үйлийн асуудлаар гүйцэтгэлийн зорилтуудыг тогтоох эсвэл компанийн түвшинд тогтоосон зорилтуудыг баримталдаг уу?. Үүнд доорх зүйлс багтсан уу?:				
	a.	Гүйцэтгэлийн зорилтуудыг хангах зорилгоор үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан уу ?				
	b.	Гүйцэтгэлийн зорилтуудыг хангахад гарч буй ахиц, энэ талаарх дотоод тайлагнал явагдаж буйг нотлон харуулах.				
Үзүүлэлт 3 Түвшин АА	4.	Шаардлагатай үед нь ажилчдын сэтгэл санааны эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх хөтөлбөрийг боловсруулсан уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь А түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					

Үзүүлэлт 3 Түвшин ААА	1.	А болон АА түвшний шалгуур дээр дотоод аудитыг багадаа гурван жил тутамд хийдэг үү?				
	a.	Дотоод аудит нь уул уурхайн салбарт төлөөлөл хомс/ хязгаарлагдмал ажил хөдөлмөрийн бүлэг, хувь хүмүүсийн оролцоог хангаж олон янз байдал, туршлагыг харгалзан хийгддэг үү?				
	b.	Дотоод аудитын үр дүнг ажилчдад мэдээлж, олон нийтэд тайлагнадаг уу?				
	2.	Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэлийн орон нутгийн орчинд урамшуулан дэмжихийн тулд хамаарах сонирхолын талуудын бүлэгтэй хамтран ажилладаг уу?				
	3.	Уурхай нь сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэлийн зарчмуудыг өөрийн худалдан авалт болон гэрээт гүйцэтгэгч нарын харилцаанд уялдуулан нэгтгэсэн үү?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэл нь ААА хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь АА түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ						Түвшин: _____

	АСУУЛТ	T	Y	NA	Талбайр болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 4: Сургалт, зан төлөв болон соёл					
Үзүүлэлт 4 Түвшин В	1.	Эрүүл мэнд, аюулгүй байдал, аюул, эрсдэлийн суурь сургалт, үүнд өндөр үр дагавар бүхий чиг үүрэг зэргийг багтаасан сургалт уурхай дээр хийж, сургалтын бүртгэлийг хөтөлдөг үү?			
	2.	Сэтгэл санааны аюулгүй байдал, хүндэтгэлт зан төлөв, нийгэм сэтгэл санааны аюулыг илрүүлэх, нийгэм сэтгэл санааны эрсдэлийг үнэлэх зэрэг суурь сургалтуудыг уурхай дээр хийж, сургалтын бүртгэлийг хөтөлдөг үү?			
	3.	Уурхай нь А түвшний бүх шаардлагуудыг ханган биелүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан уу?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь С түвшинг хангасан хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 4 Түвшин А	1.	Аюулгүй, эрүүл, хүндлэлтэй ажлын байрны тухай сургалт, мэдлэг олгох хөтөлбөрийг төлөвлөж, баримтжуулж, хэрэгжүүлдэг үү? Үүнд доорх зүйлс багтсан уу?:			
	a.	Ажилтнуудын сургалтын хэрэгцээний дүн шинжилгээ, үүнд шаардлагатай ур чадвар, чадамжийг оруулсан байх?			
	b.	Ажилтнууд болон уурхай дээрх гүйцэтгэгч нарт зориулсан сургалт ?			
	c.	Зочдод зориулсан танилцуулах сургалт?			
	d.	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үүнд сургалтын үр дүнг хянан үзэх механизм багтсан байх?			
	e.	Сургалтын бүртгэлийг хөтөлдөг байх?			
	f.	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үргэлжлүүлэхэд шаардлагатай нөөц эх үүсвэрийг хуваарилсан байх?			

Үзүүлэлт 4 Түвшин А	g.	Шаардлагатай сургалтын хөтөлбөрийг дүүргэсний дараа ажилчдын чадамжийг үнэлдэг байх?				
	h.	Сургагч нарын чадамж бүрдсэн болон/эсвэл сургалтын хөтөлбөр чанартай буйг баталгаажуулах үйл явц.				
	i.	Ажлын байран дээр аюулгүй зан төлөв, практик хэрэгжиж байх, коучинг үйлчилгээ хангагдаж буйг баталгаажуулах, сургалтуудыг сайжруулах зорилгоор биеийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажил үүргийн ажиглалтын хөтөлбөр хэрэгжүүлэх?				
	j.	Сургалтуудад дэмжлэг үзүүлэх, сайжруулахуйц сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэлд зориулсан ажиглалт, оролцооны хөтөлбөр.				
	k.	Уурхай нь аюулыг илрүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийх, хяналтыг тогтоох, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хүндлэл бүхий ажлын байрны зорилтуудыг тогтооход ажилчдын оролцоог хангах механизм бүрдэн тогтсон байх?				
	2.	Сургалт болон мэдлэг олгох хөтөлбөр нь сэргийлэх болон урьдчилсан арга хэмжээнд төвлөрсөн, аюулыг илрүүлэх болон хяналтыг багтаасан байх. Энэ нь сэтгэл санааны болон биеийн аюулыг хамарч, эдгээр асуудалд арга хэмжээ авах дотоод болон гадаад механизмуудыг ханган өгсөн үү?				
Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь В түвшинг хангасан хэмээн үнэлнэ.						
Үзүүлэлт 4 Түвшин АА	1.	Уурхай нь аюулгүй, эрүүл, хүндэтгэлт ажлын байрын шалгууруудыг өөрийн үндсэн бизнесийн процесс, арга ажиллагаанд тусгах замаар байгууллагын оролцоог хангаж, үүнд доорх багтсан уу?:				
	a.	Жил тутмын бизнесийн стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө?				
	b.	Худалдан авалтын шийдвэр?				

Үзүүлэлт 4 Түвшин АА	с.	Гүйцэтгэлийн үнэлгээний үйл явц?				
	d.	Нөхөн олговор, урамшууллын систем (жишээ нь нөхөн олговор, урамшуулал нь аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлээс хамаарч)?				
	2.	Биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал, хүндлэл, хүртээмжид тэргүүлэх ач холбогдол өгсөн ажлын байрны дизайн, соёлын заавар мөрдөгдөж байна уу?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь А түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
Үзүүлэлт 4 Түвшин ААА	1.	Эрүүл, аюулгүй, хүндлэл бүхий ажлын байрыг бий болгох хүчин чармайлт нь нийт уурхайн хэмжээнд харагдахуйц байдлаар тусгагдан хэрэгжиж байна уу?				
	2.	Уурхайн удирдлага нь ажилтнуудтай харилцахдаа эрүүл, аюулгүй, хүндлэл бүхий зан төлөв, соёлыг ажлын харагдахуйц байдлаар үлгэрлэдэг үү?				
	3.	Сургалтын хөтөлбөрүүдийн үр дүнтэй байдалд мониторинг хийх, үнэлэх үйл явц бүрдэн тогтсон уу?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэл нь ААА хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь АА түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ						Түвшин: _____

АСУУЛТ		T	Y	NA	Талбайр болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 5: Мониторинг болон тайлагнал					
Үзүүлэлт 5 Түвшин В	1.	Сургалт, аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийн үндсэн хэмжүүрүүдэд байнгын мониторинг хийж, уурхайн удирдлагад тайлагнадаг байх, энэ нь зохицуулалтын хүрээнд заасан шаардлагаас давсан уу?			
	2.	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийг уурхай дотроо тайлагнан мэдээлж, илгээдэг үү?			
	3.	Уурхай нь А түвшний бүх шаардлагуудыг ханган биелүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан уу?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь С түвшинг хангасан хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 5 Түвшин А	1.	Биеийн болон сэтгэл санааны эрүүл мэнд, аюулгүй байдлын баримтжуулсан мониторинг, тайлагнал явагдаж, доорх зүйлс багтдаг уу?:			
	a.	Гүйцэтгэлийн хэмжүүрийг ойлгомжтой тодорхойлж, зөв зохистой баримтлан хэрэглэж, байнга үнэлж (мөн салбарын нийтлэг гүйцэтгэлтэй харьцуулан), дотооддоо тайлагнах?			
	b.	Гүйцэтгэлийн хэмжүүрийг ашиглан шийдвэр гаргалтыг мэдээллээр хангах, байнгын сайжруулалтыг чиглүүлэх зорилгоор хандлагад дүн шинжилгээ хийхэд ашиглах?			
	c.	Сэтгэл санааны аюулгүй байдал, хүндэтгэлт зан төлөвтэй холбоотойгоор мэдээлсэн асуудлуудын тоо болон төрлийн талаарх өгөгдлийг цуглуулж, өгөгдөлд байнгын мониторинг, дүн шинжилгээ хийх?			

Үзүүлэлт 5 Түвшин А	d.	Тэргүүлэх болон хоцрогдол бүхий үзүүлэлтүүдийг судлах, аюулгүй байдал эрүүл мэнд болон үйлдвэрлэлийн эрүүл ахуйн хяналт шалгалт, авах арга хэмжээ, дотооддоо тайлагнах явцыг багтаасан биеийн аюулгүй байдал, эрүүл мэндийн мониторингийн хөтөлбөр?				
	e.	Биеийн эрүүл мэнд, аюулгүй байдлын аудитын хөтөлбөр хэрэгжүүлэх, менежментийн тогтолцооны аудитыг төлөвлөгөөний дагуу хийх?				
	f.	Бие махбодын аюулгүй байдал, эрүүл мэндийн мониторинг, аудитын хөтөлбөр нь өндөр үр дагавар бүхий аюул дээр төвлөрөх?				
	g.	Уурхай нь өөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн менежментийн тогтолцооны хангалттай, үр дүнтэй байдлыг жил тутамд үнэлэх, цаашид сайжруулах зөвлөмжүүдийг гаргах?				
	h.	Цаашид байнга сайжруулах, шийдвэр гаргалтыг мэдээллээр хангахын тулд биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал, эрүүл мэндийн гүйцэтгэлд удирдлагын байнгын хяналтыг хийх?				
	i.	Ажлын байрны мониторинг, хяналт шалгалтын үр дүн, авсан арга хэмжээг бүртгэж, уурхай дотроо мэдээлэх?				
	j.	Биеийн болон сэтгэл санааны аюулгүй байдал, эрүүл мэндийн гүйцэтгэлийг багадаа жилд нэг удаа олон нийтэд мэдээлдэг байх?				
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь В түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					

Үзүүлэлт 5 Түвшин АА	1.	Аюулгүй байдал ба эрүүл мэндийн өгөгдөл, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, тайлагнах үйл явц нь А түвшний шаардлагуудыг хангасан эсэх дээр дотоод аудит хийгдсэн үү?				
	2.	Биеийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эгзэгтэй байдлын хяналтын гүйцэтгэлд хамаарах босго ба өдөөгч нөхцөлүүдийг боловсруулж, хэрэгжүүлж буй, зарим босго ба өдөөгч нь бүрдсэн үү?				
	3.	Бие махбодын аюулгүй байдал, эрүүл мэндийн мониторингийн хөтөлбөрт эгзэгтэй байдлын хяналтад төвлөрөх байдлыг багтаасан уу?				
	4.	Уурхай нь хүндэтгэлт ажлын байр, ажлын байртай холбоотой асуудлаар хариу өгөх механизмд мэдээлсэн байдал, хариу арга хэмжээ, шийдсэн байдал болон/эсвэл авсан арга хэмжээний талаарх нэгтгэсэн, нэр нууцалсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх, байнгын мониторинг, шинжилгээ хийдэг үү?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь А түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
Үзүүлэлт 5 Түвшин ААА	1.	Аюулгүй байдал ба эрүүл мэндийн өгөгдөл, мэдээлэл цуглуулах, нэгтгэх, тайлагнах үйл явц нь А түвшний шаардлагуудыг хангасан эсэх дээр гадаад аудит хийгдсэн үү?				
	2.	Үр дүнтэй байдлын дотоод үнэлгээ хийгдэж, тодорхойлон гаргасан сайжруулах боломжуудыг хянах үйл явц тогтсон байх. Үүнд мөрдөн шалгах ажиллагаа болон авсан арга хэмжээний чанарыг үнэлэн ирээдүйд үргэлжлүүлэн сайжруулалт хийхэд хувь нэмэр оруулж байна уу?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэл нь ААА хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь АА түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ						Түвшин: _____

АСУУЛТ		Т	Ү	NA	Талбайр болон нотолгоо
ҮЗҮҮЛЭЛТ 6: Биеийн аюулгүй байдал, эрүүл мэндийн гүйцэтгэл					
Үзүүлэлт 6 Түвшин В	1.	Биеийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийн зорилтот түвшнүүдийг уурхайн ажилтнууд дээр тогтоосон уу?			
	2.	Зорилтот түвшний талаар ажилтнуудад мэдээлэн, харилцдаг уу?			
	3.	Уурхай нь А түвшний бүх шаардлагыг ханган биелүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан уу?			
	Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол А түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв В түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь С түвшинг хангасан хэмээн үнэлнэ.				
Үзүүлэлт 6 Түвшин А	1.	Гүйцэтгэлийн зорилтот түвшнүүд нь уурхай дээрх гэрээт гүйцэтгэгчдийг багтаасан уу?			
	2.	Уурхайн удирдлага нь зорилтот түвшинд хамаарах гүйцэтгэлийг хянах, сайжруулахад оролцдог уу?			
	3.	Гүйцэтгэлийн үр дүнгүүдийг ажилтнууд болон уурхай дээр гэрээт гүйцэтгэгч нарт мэдээлэн, харилцдаг уу?			
	4.	Уурхай дээр тайлант жилд хүний амь нас эрсэдсэн тохиолдол гараагүй юу?			
	Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол АА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв А түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь В түвшинг хангасан хэмээн үнэлнэ.				

Үзүүлэлт 6 Түвшин АА	1.	Гүйцэтгэлийн зорилтот түвшнийг тэргүүлэх болох хоцрогдол бүхий үзүүлэлтүүд дээр тодорхойлсон уу?				
	2.	Ахлах удирдлагын зүгээс гүйцэтгэлийг уурхайн зорилтот түвшин болон хамаарах сайжруулах төлөвлөгөөтэй харьцуулан хянадаг уу?				
	3.	Уурхай (эсвэл компани) нь өөрийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийг ижил төстэй уурхай, компанитай жишиж үздэг үү?				
	Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол ААА түвшний асуулт руу шилжинэ. Хэрэв АА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь А түвшинг хангасан хэмээн үнэлнэ.					
Үзүүлэлт 6 Түвшин ААА	1.	Уурхай нь байнга сайжруулах гүйцэтгэлийн зорилтот түвшнийг (багадаа өнгөрсөн 4 жилийн 3 жилд нь) ханган биелүүлсэн болон нийт 4 жилийн хугацаанд хүний амь нас эрсэдсэн тохиолдолгүй байгаа юу?				
	2.	Уурхай нь аюулгүй байдал ба эрүүл мэндийн гүйцэтгэлийн үнэн бодит, найдвартай байдлыг баталгаажуулах зорилгоор гадаад аудит хийлгэсэн үү?				
	Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгсөн бол уурхайн гүйцэтгэл нь ААА хэмээн үнэлнэ. Хэрэв ААА түвшний бүх асуултад “Тийм” гэсэн хариулт өгөөгүй бол уурхайн гүйцэтгэл нь АА түвшинг хангасан хэмээн үнэлнэ					
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ 3 ДЭЭРХ ҮНЭЛГЭЭ						Түвшин: _____



**ТОГТВОРТОЙ
УУЛ УУРХАЙН
ТӨЛӨӨ**

**Аюулгүй, эрүүл, хүндлэлтэй
ажлын байрны протокол**

ТУУТ санаачилгын талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:

www.TSMInitiative.com

эсвэл

Канадын Уул Уурхайн Ассоциаци

www.mining.ca/tsm

Энэхүү нийтлэлийг боловсрол болон ашгийн бус бусад зорилгоор Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлахыг зөвшөөрнө. Гэхдээ эх сурвалжийг бүрэн дурдсан байх шаардлагатай.

Энэхүү нийтлэлийг борлуулах болон бусад арилжааны зориулалтаар хуулбарлахыг Канадын Уул Уурхайн Ассоциацийн урьдчилсан бичгийн зөвшөөрөлгүйгээр хориглоно.

©2021 Канадын Уул Уурхайн Ассоциаци. Towards Sustainable Mining®, TSM®, зэрэг барааны тэмдгүүд нь Канад эсвэл бусад улс орнуудад Канадын Уул Уурхайн Ассоциацийн бүртгэлтэй эсвэл бүртгэлгүй барааны тэмдэг болно.



**МОНГОЛЫН УУЛ УУРХАЙН
ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ**

 www.miningmongolia.mn

 Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци

 Mongolian National Mining Association

 @miningmongolia

 @mongolian_mining_association

 Info@miningmongolia.mn

 +976 7011 0163